

ХААН БАНК ХК-ИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Жилийн үйл ажиллагааны тайлагнал			
Тайлагнах хугацаа		2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр	
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар		Нэр: ХААН Банк ХК УБГД: 000283102 РД: 2693321 Үнэт цаасны үсгэн тэмдэг: MN0KHAN05637 Хаяг: ХААН Банк Цамхаг, Чингисийн Өргөн Чөлөө-6, Стадион Оргил-1, Хан-Уул Дүүрэг 15-р хороо, Улаанбаатар 17010, Монгол Улс Утас: 1800-1917, 7515-3333/3221/, 7507-1917 И-мэйл: investor_relations@khanbank.com Вэбсайт: www.khanbank.com	
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр		Монголын Хөрөнгийн Бирж ХК	
Бизнесийн үйл ажиллагааны салбар		Банк, санхүүгийн салбар	
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо		ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК Аудитаар бүртгүүлсэн огноо – 2010 он	
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг		1,912,198,000 ширхэг энгийн хувьцаа	
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр		Бэлтгэсэн: Т.Буянбилэг /Хөрөнгө оруулагчдын харилцааны мэргэжилтэн, ТУЗ-ийн Ажлын алба/ Хянасан: В.Янжинлхам /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/	
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан		
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН (IFRS-д нийцсэн)			
Төгрөгөөр			2025-12-31
	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5,387,120,262,705.89	6,128,917,856,164.41
1.1.1	Бэлэн мөнгө	169,843,089,445.23	204,400,108,485.10
1.1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө (3 хүртэлх сарын хугацаатай)	960,978,152,925.38	2,118,087,241,425.26
1.1.3	Мөнгөтэй адилтгах хөрөнгө	4,256,092,323,238.35	3,805,230,459,507.51
1.1.4	Мөнгөн хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	206,697,096.93	1,200,046,746.54
1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	1,640,325,618,759.00	2,194,992,988,422.77
1.2.1	Монголбанкинд байршуулсан хөрөнгө	1,652,362,154,950.86	2,214,651,756,811.25

1.2.2	Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	6,780,000,000.00	260,000,000.00
1.2.3	Бусад хөрөнгө	-	-
1.2.4	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	225,327,945.21	9,164,109.59
1.2.5	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн эрсдэлийн сан	(19,041,864,137.07)	(19,927,932,498.07)
1.3	Хөрөнгө оруулалт	1,360,074,533,989.11	1,131,669,017,037.34
1.3.1	Арилжааны үнэт цаас	-	-
1.3.2	Борлуулахад бэлэн үнэт цаас	341,414,287,001.33	366,085,386,960.85
1.3.3	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас	912,850,109,459.04	673,689,141,335.21
1.3.4	Зээл ба авлага гэж ангилсан бусад үнэт цаас	-	-
1.3.5	Хараат, хамтын хяналттай, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	-	-
1.3.6	Барьцаанд байгаа үнэт цаас	85,111,769,264.22	66,759,231,610.15
1.3.7	Үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	32,645,852,634.75	27,336,869,684.37
1.3.8	Үнэт цаасны эрсдэлийн сан	(11,947,484,370.23)	(2,201,612,553.23)
1.4	Зээл (цэвэр дүнгээр)	11,195,929,983,967.60	13,534,112,172,378.80
1.4.1	Хэвийн зээл	11,157,561,811,383.70	13,321,042,127,409.30
1.4.2	Хугацаа хэтэрсэн зээл	219,752,897,145.20	386,122,653,138.16
1.4.3	Хэвийн бус зээл	112,294,049,458.13	108,307,403,343.05
1.4.4	Эргэлзээтэй зээл	72,235,443,436.84	130,357,510,251.25
1.4.5	Муу зээл	332,009,641,510.35	378,937,196,538.00
1.4.6	Зээлийн хойшлогдсон төлбөр	(103,587,293,505.28)	(111,035,822,693.10)
1.4.7	Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	140,791,052,504.34	159,114,931,917.28
1.4.8	Зээлийн эрсдэлийн сан	(735,127,617,965.73)	(838,733,827,525.14)
1.5	Дериватив санхүүгийн хөрөнгө	29,176,723,444.80	84,233,498,042.33
1.6	Бусад санхүүгийн хөрөнгө	49,345,876,302.29	77,743,147,882.47
1.6.1	Бусдаас авах авлага (цэвэр дүнгээр)	38,777,989,360.76	54,783,490,089.62
1.6.2	Банк, салбар хоорондын тооцоо	4,348,294,670.86	7,696,622,982.26
1.6.3	Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр дүнгээр)	-	-
1.6.4	Бусад	6,219,592,270.67	15,263,034,810.59
1.7	Бусад санхүүгийн бус хөрөнгө	132,393,610,736.27	210,157,561,590.60
1.7.1	Бусад тооцоо	118,604,456,924.72	162,032,506,809.01
1.7.2	Бараа материал, үнэ бүхий зүйл	13,789,153,811.55	10,355,811,848.88
1.7.3	Үнэт металл (цэвэр дүнгээр)	-	-
1.7.4	Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр дүнгээр)	-	-
1.7.5	Татварын авлага	-	37,769,242,932.71
1.7.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.7.7	Бусад	-	-
1.8	Үндсэн хөрөнгө	473,566,293,211.13	542,474,454,429.66
1.9	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.10	Борлуулах зориулалттай хөрөнгө	414,487,891.10	425,626,826.83
1.11	Биет бус хөрөнгө	34,377,217,100.52	37,582,954,367.94
1.12	Нийт хөрөнгийн дүн	20,302,724,608,107.70	23,942,309,277,143.20
2	ӨР ТӨЛБӨР		
2.1	Харилцах	5,007,554,265,245.24	4,564,547,901,266.55
2.1.1	Харилцах дансны нэрлэсэн үлдэгдэл	5,007,554,265,245.24	4,564,547,901,266.55
2.1.2	Харилцах дансанд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	-	-
2.2	Хадгаламж	8,891,415,790,781.43	10,197,266,433,977.80
2.2.1	Хугацаагүй хадгаламж	2,167,802,131,034.83	2,346,060,474,486.73
2.2.2	Хугацаатай хадгаламж	6,481,848,611,390.16	7,547,239,901,894.14
2.2.3	Бусад төрлийн хадгаламж	810,000,000.00	242,001,210.96

2.2.4	Хадгаламжинд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	240,955,048,356.44	303,724,056,385.94
2.3	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	2,669,966,881,192.33	4,444,039,404,651.60
2.3.1	Банк, санхүүгийн байгууллагаас байршуулсан харилцах, хадгаламж	314,086,546,077.81	643,474,474,587.63
2.3.2	Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл (хугацаа хэтэрсэн зээлийн дүнг оруулсан)	2,320,627,795,268.83	3,771,897,396,327.04
2.3.3	Эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	(11,706,739,138.22)	(25,947,249,235.97)
2.3.4	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	46,959,278,983.91	54,614,782,972.90
2.4	Бусад эх үүсвэр	1,019,855,687,521.80	1,638,348,457,777.45
2.4.1	Банкнаас гаргасан өрийн бичиг	35,912,625,000.00	26,667,000,000.00
2.4.2	Банкнаас гаргасан үнэт цаас	752,353,750,000.00	777,385,536,008.98
2.4.3	Төслийн зээлийн санхүүжилт	81,041,535,593.75	75,569,723,048.35
2.4.4	Буцаан худалдан авах нөхцөлөөр худалдсан үнэт цаас (репо)	87,791,865,061.06	65,803,113,309.08
2.4.5	Хамтын зээлжүүлэлтийн эх үүсвэр	-	-
2.4.6	Бусад	55,156,905,564.55	682,396,109,039.67
2.4.7	Бусад эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	(6,428,107,647.63)	(3,815,201,362.49)
2.4.8	Бусад эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	14,027,113,950.07	14,342,177,733.86
2.5	Дериватив санхүүгийн өр төлбөр	-	18,972,146,144.51
2.6	Бусад санхүүгийн өр төлбөр	164,706,715,084.30	156,977,671,926.33
2.7	Бусад санхүүгийн бус өр төлбөр	84,567,020,937.35	97,317,454,279.91
2.8	Хоёрдогч өглөг	-	-
2.9	Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	-	-
2.10	Нийт өр төлбөрийн дүн	17,838,066,360,762.45	21,117,469,470,024.15
3	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		
3.1	Хувь нийлүүлсэн хөрөнгө	191,219,800,000.00	191,219,800,000.00
3.1.1	Давуу эрхийн хувьцаа	-	-
3.1.2	Энгийн хувьцаа	191,219,800,000.00	191,219,800,000.00
3.2	Нэмж төлөгдсөн капитал	164,257,808,200.00	164,257,808,200.00
3.3	Халаасны хувьцаа	-	-
3.4	Дахин үнэлгээний нэмэгдэл	84,328,874,854.19	123,003,937,422.34
3.5	Хуримтлагдсан ашиг, алдагдал	2,018,390,801,117.22	2,342,390,788,343.78
3.6	Бусад өөрийн хөрөнгө	6,460,963,173.84	3,967,473,152.93
3.6.1	Хувьцааны опцион	-	-
3.6.2	Нөөцийн сан	-	-
3.6.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн сан	-	-
3.6.4	Эрсдэлийн сангийн нөөц	-	-
3.6.5	Нийгмийн хөгжлийн сан	-	-
3.6.6	Хувьцаанд хөрвөх үнэт цаас (өөрийн хөрөнгө)	-	-
3.6.7	Хувьцаанд хөрвөх эх үүсвэр (өөрийн хөрөнгө)	-	-
3.6.8	Борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний сан	7,029,919,942.60	8,685,490,044.13
3.6.9	Хейджийн хэрэгслийн дахин үнэлгээний сан	(568,956,768.76)	(4,718,016,891.20)
3.6.10	Бусад	-	-
3.7	Өөрийн хөрөнгийн дүн	2,464,658,247,345.25	2,824,839,807,119.05
4	Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	20,302,724,608,107.70	23,942,309,277,143.20

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

<i>Төгрөгөөр</i>		<i>2025/12/31</i>	
	Орлого, зардлын зүйл	Өмнөх үеийн дүн	Тайлант үеийн дүн
1	Хүүгийн орлого	2,553,680,935,641.85	2,936,655,663,558.64
1.1	Монголбанкинд байршуулсан хөрөнгийн	37,672,814,573.20	17,925,834,708.38

1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	8,899,382,728.11	6,882,987,127.56
1.3	Үнэт цаасны	576,803,745,148.97	491,807,198,966.10
1.4	Зээлийн	1,767,941,598,644.73	2,242,765,094,274.06
1.5	Бусад хүүгийн орлого	162,363,394,546.84	177,274,548,482.54
2	Хүүгийн зардал	1,327,175,669,551.34	1,596,123,205,250.31
2.1	Харилцахад төлсөн хүү	36,708,697,932.76	39,290,256,615.34
2.2	Хадгаламжинд төлсөн хүү	830,808,959,682.66	875,903,191,133.85
2.3	Зээлийн хүүгийн зардал	169,746,313,098.03	242,327,406,788.74
2.4	Үнэт цаасны хүүгийн зардал	45,604,474,203.03	79,097,163,036.55
2.5	Бусад хүүгийн зардал	244,307,224,634.86	359,505,187,675.83
3	Хүүгийн цэвэр орлого [(1)-(2)]	1,226,505,266,090.51	1,340,532,458,308.33
4	Эрсдэлийн сангийн зардал	101,665,509,802.56	109,727,418,719.20
4.1	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	5,147,445,250.00	886,068,361.00
4.2	Үнэт цаасны	5,988,005,100.00	-
4.3	Зээлийн	90,530,059,452.56	108,841,350,358.20
5	Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого [(3)-(4)]	1,124,839,756,287.95	1,230,805,039,589.13
6	Бусад орлого	464,947,315,337.56	636,876,871,148.61
6.1	Хүүгийн бус орлого	448,918,871,250.67	600,852,999,634.80
6.1.1	Арилжааны орлого	56,255,864,794.90	87,469,806,308.67
6.1.2	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого	56,625,505,207.29	149,635,583,143.55
6.1.3	Банкны бүтээгдэхүүнтэй холбоотой үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	336,037,501,248.48	363,747,610,182.58
6.1.4	Бусад хүүгийн бус орлого	-	-
6.2	Бусад орлого, олз	16,028,444,086.89	36,023,871,513.81
7	Бусад зардал	759,855,586,780.00	988,635,322,977.32
7.1	Хүүгийн бус зардал	746,049,866,324.68	974,200,280,534.11
7.1.1	Бусад эрсдэлийн сангийн зардал	12,684,500,238.29	10,108,790,232.94
7.1.2	Арилжааны зардал	24,906,761,288.71	58,458,914,044.28
7.1.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн зардал	56,159,021,656.75	139,313,738,579.53
7.1.4	Хураамж, шимтгэлийн зардал	46,221,390,223.35	54,827,597,023.11
7.1.5	Үйл ажиллагааны бусад зардал	606,078,192,917.58	711,491,240,654.25
7.2	Бусад зардал, гарз	13,805,720,455.32	14,435,042,443.21
8	Татварын өмнөх ашиг, алдагдал (5+6-7)	829,931,484,845.51	879,046,587,760.42
9	Орлогын татварын зардал	191,417,028,231.15	184,199,370,689.34
10	Татварын дараах ашиг, алдагдал (8-9)	638,514,456,614.36	694,847,217,071.08
11	Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал	-	-
12	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал (10+11)	638,514,456,614.36	694,847,217,071.08
13	Бусад дэлгэрэнгүй орлого	3,570,677,921.53	36,181,572,547.24
13.1	Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны өсөлт, бууралт	(1,853,576,973.03)	38,675,062,568.15
13.2	Борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний өсөлт, бууралт	3,263,229,899.79	1,655,570,101.53
13.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн сангийн өсөлт, бууралт		
13.4	Эрсдэлийн сангийн нөөцийн өсөлт, бууралт	-	
13.5	Бусад	2,161,024,994.77	(4,149,060,122.44)
14	Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн (10+11)	642,085,134,535.89	731,028,789,618.32

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

<i>Төгрөгөөр</i>								<i>2025/12/31</i>
	Өөрийн хөрөнгийн зүйл	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Нэмж төлөгдсөн капитал	Халаасны хувьцаа	Дахин үнэлгээний нэмэгдэл	Бусад өөрийн хөрөнгө	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл	191,219,800,000.00	164,257,808,200.00	-	86,182,451,827.22	1,036,708,279.28	1,649,038,590,069.83	2,091,735,358,376.33
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							-
3	Залруулсан үлдэгдэл	191,219,800,000.00	164,257,808,200.00	-	86,182,451,827.22	1,036,708,279.28	1,649,038,590,069.83	2,091,735,358,376.33
4	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-	-	-	-	-	638,514,456,614.36	638,514,456,614.36
5	Бусад дэлгэрэнгүй орлого					5,424,254,894.56		5,424,254,894.56
6	Өмчид гарсан өөрчлөлт							-
7	Хуваарилсан ногдол ашиг	-		-	-	-	(271,015,822,540.00)	(271,015,822,540.00)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	(1,853,576,973.03)		1,853,576,973.03	-
9	2024 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл	191,219,800,000.00	164,257,808,200.00	-	84,328,874,854.19	6,460,963,173.84	2,018,390,801,117.22	2,464,658,247,345.25
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							-
11	Залруулсан үлдэгдэл	191,219,800,000.00	164,257,808,200.00	-	84,328,874,854.19	6,460,963,173.84	2,018,390,801,117.22	2,464,658,247,345.25
12	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-	-	-	-	-	694,847,217,071.08	694,847,217,071.08
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	41,375,712,023.63	(2,493,490,020.91)		38,882,222,002.72
14	Өмчид гарсан өөрчлөлт							-
15	Хуваарилсан ногдол ашиг	-		-	-	-	(373,547,879,300.00)	(373,547,879,300.00)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	(2,700,649,455.48)		2,700,649,455.48	-
17	2025 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл	191,219,800,000.00	164,257,808,200.00	-	123,003,937,422.34	3,967,473,152.93	2,342,390,788,343.78	2,824,839,807,119.05

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Төгрөгөөр

2025/12/31

	Үзүүлэлт	Өмнөх үеийн дүн	Тайлант үеийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:	***	***
1.1	Орлогын татварын өмнөх ашиг (алдагдал)	830,231,484,845.51	879,046,587,760.42
1.2	Орлого, зардлын тохируулга:	(1,013,578,240,916.08)	(1,155,783,312,065.35)
1.2.1	Эрсдэлийн сангийн зардал (+)	114,350,010,040.85	119,835,566,626.14
1.2.2	Элэгдэл, хорогдлын зардал (+)	74,200,806,869.55	86,271,479,398.59
1.2.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого (-), зардал (+) (Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөөс бусад)	7,616,282,920.38	13,550,599,408.63
1.2.4	Хуримтлуулсан хүүгийн орлого (-)	(2,553,680,935,641.85)	(2,936,655,663,558.64)
1.2.5	Хуримтлуулсан хүүгийн зардал (+)	1,327,175,669,551.34	1,596,123,205,250.31
1.2.6	Хөрөнгө данснаас хассаны олз (-), гарз (+)	90,005,200.14	23,354,261.00
1.2.7	Бусад олз (-), гарз (+)	16,669,920,143.51	(34,931,853,451.38)
1.3	Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн тохируулга:	(906,102,404,633.75)	(505,006,374,351.16)
1.3.1	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	(542,122,137,402.76)	(555,769,601,860.39)
1.3.2	Арилжааны үнэт цаасны өсөлт (-), бууралт (+)	-	-
1.3.3	Зээлийн өсөлт (-), бууралт (+)	(2,238,888,156,632.27)	(2,423,381,695,147.71)
1.3.4	Бусад санхүүгийн хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	(42,525,477,725.50)	(28,397,271,580.18)
1.3.5	Бусад санхүүгийн бус хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	(43,456,079,104.94)	(87,872,098,761.27)
1.3.6	Харилцах, хадгаламжийн өсөлт (+), бууралт (-)	1,706,191,186,224.68	809,158,774,477.41
1.3.7	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн өсөлт (+), бууралт (-)	258,932,318,485.43	1,766,417,019,470.28
1.3.8	Бусад санхүүгийн өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-)	(22,999,099,530.70)	(6,827,814,938.23)
1.3.9	Бусад санхүүгийн бус өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-)	18,765,041,052.30	21,666,313,988.94
1.4	Бусад тохируулга:	1,068,622,586,328.40	1,145,888,922,530.85
1.4.1	Авсан хүү (+)	2,545,960,169,525.25	2,923,459,995,344.17
1.4.2	Төлсөн хүү (-)	(1,261,644,526,646.45)	(1,525,383,629,448.03)
1.4.3	Орлогын татварын төлөлт (-)	(207,824,527,071.90)	(246,869,479,156.50)
1.4.4	Эрсдэлийн сангаас хаасан зээл, авлага (-)	(7,868,529,478.50)	(5,317,964,208.79)
1.5	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:	(20,826,574,375.92)	364,145,823,874.76
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	***	***
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	292,473,907,769.96	224,630,051,465.44
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	394,254,084.79	540,167,814.44
2.1.3	Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.4	Охин компани, хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.6	Зээл ба авлага гэж ангилан хорогдуулсан өртгөөр бүртгэсэн хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-

2.1.7	Борлуулахад бэлэн үнэт цаас борлуулсны орлого	-	-
2.1.8	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас борлуулсны орлого	-	-
2.1.9	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.1.10	Бусад мөнгөн орлого	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	292,079,653,685.17	224,089,883,651.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(74,661,218,732.66)	(82,524,605,764.23)
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	66,837,683,245.08	65,137,347,544.66
2.2.3	Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	7,823,535,487.58	17,387,258,219.57
2.2.4	Охин компани, хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Зээл ба авлага гэж ангилан хорогдуулсан өртгөөр бүртгэсэн хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.6	Борлуулахад бэлэн үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.7	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.8	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.9	Бусад мөнгөн зарлага	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:	217,812,689,037.30	142,105,445,701.21
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	***	***
3.1.1	Бусад эх үүсвэр татаж хүлээн авсан	567,384,845,852.71	609,094,203,182.55
3.1.2	Хоёрдогч өглөгөөс хүлээн авсан	-	-
3.1.3	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.4	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.5	Бусад	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	567,384,845,852.71	609,094,203,182.55
3.2.1	Бусад эх үүсвэрт төлсөн	(271,015,822,540.00)	(373,547,879,300.00)
3.2.2	Хоёрдогч өглөгт төлсөн	-	-
3.2.3	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.4	Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн	-	-
3.2.5	Төлсөн ногдол ашиг	-	-
3.2.6	Бусад	271,015,822,540.00	373,547,879,300.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү	296,369,023,312.71	235,546,323,882.55
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		
6	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	493,355,137,974.09	741,797,593,458.52
7	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,893,765,124,731.80	5,387,120,262,705.89

1.1.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт
ХААН Банк ХК (“ХААН Банк”, “Банк”)-ийн 2025 оны жилийн эцсийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн 3-7 дугаар хуудаснаас харна уу.	
1.2.	Аудитын тодорхойлох захидал

Банкны 2025 оны жилийн эцсийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн 3 дугаар хуудаснаас харна уу.

2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл
2.1.	Үйл ажиллагааны үр дүн

Нийт актив:

2025 оны эцсийн байдлаар нийт актив 23.9 их наяд төгрөгт хүрч, 2024 оны эцэстэй харьцуулахад 17.9 хувийн өсөлт үзүүлсэн бөгөөд энэ нь нийт банкны систем дэх тэргүүлэх үзүүлэлт бөгөөд 2025 оны 4 дүгээр улирлаар 28 хувийг эзэлж байна.

Нийт зээл:

2025 оны эцсийн байдлаар нийт зээлийн багц 14.4 их наяд төгрөгт хүрч, 2024 оны эцэстэй харьцуулахад 2.4 их наяд төгрөг буюу 20.5 хувиар өссөн.

Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө:

Банкны нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө 18.4 хувь буюу 3.2 их наяд төгрөгөөр өсөж, 20.9 их наяд төгрөгт хүрлээ. Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 76 хувийг харилцагчаас татсан эх үүсвэр, 24 хувийг банк, санхүүгийн байгууллагаас татсан зээллэг болон бусад эх үүсвэр бүрдүүлж байна.

Өөрийн хөрөнгө:

Нийт өөрийн хөрөнгийн хэмжээ өмнөх оны эцсээс 14.6 хувь буюу 360.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 2.8 их наяд төгрөгт хүрсэн байна.

Ашигт ажиллагаа:

2025 оны эцсийн байдлаар Банк 694.8 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллалаа. Үүнд хүүгийн цэвэр орлого 1,340.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 114.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлээ. Активын өгөөж 3.3 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж 27.1 хувьтай байна.

2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт
------	---

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монголбанкны зохистой харьцаа үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ(>12%)

Нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээ өмнөх оны эцсээс 0.3 пунктээр буурч 17.46 хувьд хүрлээ.

I зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ (>13%)

I зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ өмнөх оны эцсээс 0.3 пунктээр буурч 17.46 хувьд хүрлээ.

Хөрвөх чадварын харьцаа(>25%)

Банкны хөрвөх чадварын харьцаа 42.5 хувь буюу зохистой харьцаа 25 хувиас дээш байх шалгуурыг бүрэн хангаж ажиллалаа.

Зээлийн чанар

Чанаргүй зээлийн багц 617.6 тэрбум төгрөг буюу нийт зээлд эзлэх хувь 4.3 хувь болж, өмнөх оны эцсээс 0.03 пунктээр буурлаа.

	2024	2025
Ашигт ажиллагаа		
Өөрийн хөрөнгийн өгөөж	28.9%	27.1%
Активын өгөөж	3.4%	3.3%
Зардал орлогын харьцаа	40.9%	44.4%
Зээлийн чанар		
Чанаргүй зээлийн харьцаа	4.3%	4.3%
Зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээний харьцаа	142.3%	135.8%
Монголбанкны шалгуур		
Өөрийн хөрөнгийн зохистой харьцаа (>12%)	17.8%	17.5%
1-р зэрэглэл өөрийн хөрөнгийн харьцаа (>13%)	17.8%	17.5%
Хөрвөх чадварын харьцаа (>25%)	44.5%	42.5%
Нэгж гадаад валютын нээлттэй позицын харьцаа (+15%)	-2.8%	-2.6%
Нийт гадаад валютын нээлттэй позицын харьцаа (+30%)	-3.1%	-2.7%

- 2.3. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл

Банкны хөгжлийн чиг хандлага, түүнд үзүүлэх нөлөөлөл

Дэлхийн эдийн засгийн нөлөөлөл: 2025 онд худалдааны саад хориг нэмэгдэж, тодорхой бус байдал өндөр түвшинд хадгалагдсан нөхцөл байдлыг даван туулсны дараа дэлхийн эдийн засгийн идэвхжил сайжирч 3.4%-ийн өсөлттэй байсан бол Ойрх Дорнодод дайн дэгдсэнтэй холбоотойгоор томоохон сорилттой тулгарч, уг мөргөлдөөн үргэлжлэх хугацаа болон хамрах хүрээний хувьд хязгаарлагдмал хэвээр байна гэж үзвэл дэлхийн эдийн засгийн өсөлт 2026 онд 3.1 хувь, 2027 онд 3.2 хувь болж саарахаар төсөөлөгдөж байна.

Дэлхийн инфляц 2025 онд 4.1 хувь байсан бол 2026 онд 4.4 хувь болж өсөөд, 2027 онд 3.7 хувь болж эргэн буурах төлөвтэй байна. Энэ нь 2026 оны үзүүлэлтийг 2025 оны 10 дугаар сарын “Дэлхийн эдийн засгийн төлөв” тайлантай харьцуулахад 0.7 нэгж хувиар дээш шинэчилсэн үзүүлэлт бөгөөд эрчим хүч, хүнсний үнийн өсөлт өндөр байх хүлээлттэй байна.

2025 онд дэлхийн эдийн засгийн орчин худалдааны тодорхой бус байдал, геополитикийн хурцадмал байдал, түүхий эдийн үнийн хэлбэлзэл болон Хятадын эрэлтийн өөрчлөлтөөр тодорхойлогдож, Монгол Улсад экспорт, төсөв, инфляц, төлбөрийн тэнцлийн сувгаар нөлөө үзүүлээ.

Монгол Улсын эдийн засаг, банкны салбарын тойм

Монгол Улсын эдийн засаг 2025 онд 6.8 хувиар өсөж, ДНБ 89.9 их наяд төгрөг болон өмнөх онтой харьцуулахад 9.3 (11.5%) их наяд төгрөгөөр өсөхөд хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг 2.2 (36.7%) их наяд төгрөгөөр, үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 4.1 (11.5%) их наяд төгрөгөөр, үйлдвэрлэл, барилга 2.0 (22.4%) их наяд төгрөгөөр өссөн нь нөлөөлөв.

Оны эхний хагаст БНХАУ-ын гангийн үйлдвэрлэлийн илүүдлээс шалтгаалан Монгол Улсын экспортын гол бүтээгдэхүүн болох нүүрсний үнэ огцом унаж, төлбөрийн тэнцэл болон улсын төсөвт дарамт учруулав. Гэсэн хэдий ч Оюутолгойн гүний уурхайн олборлолт эрчимжсэний хамтаар зэсийн үнэ өссөн нь уул уурхайн салбарыг дэмжиж, нүүрсний үнийн бууралттай холбоотой сөрөг нөлөөг буурууллаа. Түүнчлэн 2 жил дараалан уналттай байсан Хөдөө аж ахуй (ХАА)-н салбар цаг агаарын таатай байдлаас шалтгаалан сэргэснээр эдийн засгийн өсөлтийг голлон бүрдүүлсэн юм.

Монголбанкны мөнгөний бодлогын хорооны 2025 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн шийдвэрээр бодлогын хүүг 2 нэгж хувиар нэмэгдүүлж 12 хувьд, өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 50 хувь байхаар тогтоох, 2025 оны 9 болон 12 дугаар сарын ээлжит хурлуудаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, дотоод, гадаад орчны төлөв, эрсдэлийг харгалзан үзээд бодлогын хүүг 12 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргалаа. Энэ нь инфляцыг зорилтот түвшин рүү бууруулах, төгрөгийн өгөөжийг хадгалах, санхүүгийн тогтвортой байдлыг хамгаалах бодлогын чиглэлтэй уялдаж байна.

Жилийн инфляц 2025 оны 12 дугаар сард улсын хэмжээнд 7.5 хувь, Улаанбаатар хотод 7.6 хувьтай гарлаа. Ийнхүү инфляц өмнөх сараас буурахад төрийн зохицуулалттай үйлчилгээний үнийн өсөлтийн суурь нөлөө арилж эхэлсэн нь голлон нөлөөлөв. Түүнчлэн, зээл, санхүүжилтийн нөхцөл чангарсан, гадаад үнэ нам түвшинд хадгалагдсан, төгрөгийн ханш тогтворжсон зэрэг нь импортын бараа, үйлчилгээний инфляцыг саарууллаа.

Монгол Улсын гадаад валютын албан нөөц 7.0 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 27.1 хувиар, өмнөх сараас 19.0%-иар тус тус өсөж импортын 7.6 сарын хэрэгцээг хангах түвшинд хүрсэн бол, 2026 оны 3-р сарын байдлаар нөөц 7.2 тэрбум ам.доллар болсон нь өмнөх оны мөн үеэс 43.9%-иар, өмнөх сараас 5.7%-иар тус тус өссөн байна. Энэхүү нөөц нь импортын 8.7 сарын хэрэгцээг хангах хэмжээнд байна.

Гадаад худалдааны экспортын орлого 2025 онд 15.7 тэрбум ам.долларт хүрсэн. Экспорт өмнөх оноос 22.6 сая ам.доллараар буурахад нүүрс 2.9 тэрбум ам.доллар, угаасан ноолуур 256.7 сая ам.доллар, боловсруулаагүй газрын тос 70.3 сая ам.доллар, сүлжмэл дотуур хувцас 5.5 сая ам.доллараар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ. Харин зэсийн хүдэр ба баяжмал 2.5 тэрбум ам.доллар, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт 341.6 сая ам.доллар, мал амьтны самнасан үс, хялгас 262.4 сая ам.доллар, цайрын хүдэр, баяжмал 51.1 сая ам.доллараар өссөн байна.

Зохицуулалтын орчны нөлөөлөл: 2025 онд Монголбанк инфляцын дарамтыг бууруулах, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах, банкны системийн эрсдэлийг хязгаарлах зорилгоор мөнгөний болон макро зохистой бодлогын арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлсэн. Монголбанк 2025 оны 3 дугаар сард бодлогын хүүг 10 хувиас 12 хувь болгон нэмэгдүүлсэн бөгөөд түүнээс хойш бодлогын хүүг 12 хувьд хэвээр хадгалсан байна.

Мөн инфляцын дарамтыг бууруулах, банкны системийн эх үүсвэрийн тогтвортой байдлыг хангах зорилгоор заавал байлгах нөөцийн хувь хэмжээг нэмэгдүүлсэн. Тухайлбал, 2025 онд төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 13 хувь, гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 18 хувь болгосон бөгөөд 2025 оны сүүлээр уг шаардлагыг дахин нэмэгдүүлж, төгрөгийн хувьд 14 хувь, гадаад валютын хувьд 19 хувь болгох бодлогын чиглэл баримталсан байна.

Өрхийн өрийн дарамт, хэрэглээний зээлийн эрсдэлийг хязгаарлах хүрээнд банкуудын хэрэглээний зээлд мөрдөх өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 2025 онд 50 хувь болгон шинэчилсэн. Мөн тэтгэвэр, тэтгэмжээр баталгаажсан зээлийн хувьд зээлдэгчийн сар бүрийн үлдэх орлого нь зээлийн эргэн төлөлтийн дараа амьжиргааны доод түвшнээс дээш байх шаардлагыг тогтоосон. Энэ нь хэрэглээний зээлийн хэт өсөлтийг хязгаарлах, өрхийн санхүүгийн дарамтыг бууруулах, банкны зээлийн чанарт үүсэх эрсдэлийг урьдчилан сэргийлэх ач холбогдолтой байна.

Тэтгэврийн зээлтэй холбоотойгоор 2025 оны 12 дугаар сард тэтгэврийн зээлийн үлдэгдэл хугацааг 36 хүртэл сараар нэг удаа олгох зохицуулалтын шийдвэр гарсан. Үүний зэрэгцээ тэтгэвэр, тэтгэмжийн орлого барьцаалсан зээлийн үлдэгдэлтэй тэнцэх хэмжээний эх үүсвэрийг банкны заавал байлгах нөөц тооцох эх үүсвэрээс хасаж тооцох зохицуулалт хэрэгжихээр болсон. Энэхүү арга хэмжээ нь тэтгэвэр, тэтгэмжийн орлогоор баталгаажсан зээлийн хүртээмжийг тодорхой хэмжээнд хадгалах боловч иргэдийн өрийн дарамт, банкуудын эх үүсвэрийн удирдлага, зээлийн эрсдэлийн хяналтад эерэг нөлөөтэй байна.

Төлбөр тооцооны дэд бүтцийн хувьд олон улсын жишигт нийцсэн IBAN буюу олон улсын банкны дансны дугаарын стандарт 2025 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. IBAN стандарт нэвтэрснээр банк хоорондын гүйлгээний мэдээлэл илүү бүтэцтэй, нэгдсэн форматтай болж, гүйлгээний үнэн зөв байдал, автомат боловсруулалт, харилцагчийн дансны мэдээллийн баталгаажуулалт сайжрах нөхцөл бүрдсэн. Энэ нь банкны үйл

ажиллагааны үр ашиг, төлбөр тооцооны найдвартай байдал, алдаатай гүйлгээний эрсдэлийг бууруулахад эерэг нөлөөтэй.

ХААН Банкны үйл ажиллагааны гүйцэтгэл

ХААН Банк нь алсын хараа, эрхэм зорилготойгоо уялдуулан, тогтвортой хөгжлийг дэмжих, тогтвортойгоор өсөх стратегийн хүрээнд дөрвөн тулгуурт чиглэл бүхий тогтвортой бизнес стратегийг хэрэгжүүлэн үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна.

Харилцагчийн туршлага сайжруулах зорилгын хүрээнд, банкны нийт цахим болон биет сувгууд дээр хялбар, шуурхай, найдвартай туршлагыг сайжруулах, үр дүнтэй түншлэл болон харилцагчийн асуудлыг шийдвэрлэх хамгийн сайн процессыг олон улсын харилцагчийн туршлагын стандартын дагуу хэрэгжүүлэх, хиймэл оюун ухаан болон машин сургалтад суурилан харилцагчид тохирсон санхүүгийн бүтээгдэхүүнийг санал болгох, хиймэл оюун ухаант чатботоор дамжуулан харилцагчид санхүүгийн боловсрол, зөвлөгөө, мэдээлэл олгож хамгийн сайн харилцагчийн үйлчилгээг бий болгох стратегийг тэргүүн чиглэл болгон ажиллаж байна.

Тус зорилтын хүрээнд Generative AI-д суурилсан чатботуудаар дамжуулан дотоод ажилтнууд болон харилцагчдад санхүүгийн боловсрол, зөвлөгөө, банкны бүтээгдэхүүн үйлчилгээний талаар мэдээллийг түргэн шуурхай хүргэх зорилгоор чатботын мэдлэгийн санг нэмэгдүүлсэн ба 2025 онд нийт чатбот хандалтын 88% нь автоматаар шийдвэрлэгдсэн.

Харилцагчдадаа шинэ шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх зорилгоор 2025 онд картын рэбрэндингийг үргэлжлүүлэн хийж, Glamour кредит карт, Энгийн болон Бизнесийн дебит картуудын загвараа шинэчилж, улам хүртээмжтэй лоялти үйлчилгээтэйгээр зах зээлд нэвтрүүлсэн. Мөн аялалын Travel болон Виртуал кредит картыг шинээр нэвтрүүлэв. 2025 онд харилцагчийн худалдан авалт, төлбөр тооцоог идэвхжүүлэх нийт 57 урамшуулалт аян, хөтөлбөрүүдийг зохион байгуулсан.

Банкны үндсэн цахим суваг болох ХААН Банк аппликейшн дээр шинэ харилцагчийг зайнаас бүртгэх, дансанд хамтран эзэмшигч бүртгэх, цуцлах зэрэг процессууд болон үл хөдлөх хөрөнгө барьцаалсан онлайн бизнесийн зээлийг шинээр нэвтрүүлж, мөн салбарт хийгддэг бусад процессуудыг автоматжуулж, харилцагчийн туулах замыг сайжруулав. Улмаар, карттай харилцагчийн тоо болон цахим харилцагчийн тоо тус тус 2 саяд хүрч, ХААН Банкны нийт гүйлгээний 99.6 хувь нь цахимаар хийгдсэн. Мөн банк доторх болон банк хоорондын гүйлгээнд IBAN дугаарлалтыг бүрэн нэвтрүүлж, дансны давхардал үүсэх, харилцагчийн нэр, дансны дугаар зөрөх, гүйлгээ саатахаас сэргийлэх боломжийг сайжрууллаа. Жижиг дунд бизнес эрхлэгчдэд хэрэгцээт санхүүгийн болон санхүүгийн бус бүхий л үйлчилгээг нэг дороос, шуурхай хүргэх зорилгын хүрээнд салбар нэгжийн дахин зохион байгуулалт хийж, орон нутагт бүсийн зээлийн судалгааны төв болон Үйлчилгээний нэгдсэн төвийг байгуулахын сацуу зөвлөх ур чадвар бүхий харилцааны менежрүүдийг сургаж, бизнесийн зээлийн процессыг хялбарчлах ажлуудыг гүйцэтгэлээ.

Улмаар ХААН Банкны бүтээгдэхүүн үйлчилгээний сайжруулалтууд харилцагчдын сэтгэл ханамжид эерэг нөлөө үзүүлсэн буюу 2025 онд Приорити, Сигначур, Масс болон ЖДБ харилцагчдын сэтгэл ханамжийн NPS оноо 4.6 дахин өссөн үзүүлэлттэй байна. Мөн IDCXS буюу цахим харилцагчийн олон улсын туршлагын стандартыг 98 хувьд баталгаажуулж, олон улсын төгөлдөршил түвшинд гүйцэтгэлээ хадгалав.

Бизнесийн өсөлт, эрсдэлийн удирдлагын зорилгын хүрээнд: Бизнесийн өсөлтийг хангах чиглэлд зээлийн багцыг тэнцвэртэй өсгөх, тогтвортой санхүүжилтийг дэмжсэн ногоон зээл болон жендэрийн зээлийг нэмэгдүүлэхэд голлон анхаарч ажиллаж байгаа ба тайлант хугацаанд бизнес эрхлэгч иргэнд олгох үл хөдлөх хөрөнгө барьцаалсан бизнесийн зээлийг цахимжуулж, 200 сая төгрөгийн лимиттэй олгож эхэлээ. Байгууллагын болон ЖДБ-ийн сегментийн хувьд нийлүүлэлтийн сүлжээний ханган нийлүүлэгчдийн хамтын ажиллагааг хангах, төлбөр тооцоогоо цахимаар хийх болон тэдгээрийн бизнесийн үр ашгийг нэмэгдүүлэх боломж бүхий ХААН Бизнес аппликейшнийг зах зээлд шинээр нэвтрүүллээ. Мөн байгууллагын интернэт банк болон мерчантуудад зориулсан ХААН Мерчант аппликейшнд цахим функцүүд хөгжүүлэн нэмж, харилцагчийн үйлчилгээ авах хурдыг сайжрууллаа.

ХААН Банкны зах зээл эзлэлт:

- Нийт хөрөнгө 2025 оны жилийн эцсийн байдлаар өмнөх оны мөн үеэс 7.9 хувиар өсөж, 23.9 их наяд төгрөгт хүрсэн ба зах зээл эзлэлт 28% байна.
- Нийт зээлийн багц 20.4 хувиар өсөж, 14.3 их наяд төгрөгт хүрсэн ба зах зээл эзлэлт 32.8% байна.
- Харилцагчийн депозитын багц 8 хувиар өсөж, 15.1 их наяд төгрөгт хүрсэн ба зах зээл эзлэлт 30.3% байна.

Бизнесийн өсөлтийг дэмжих хүрээнд, ХААН Банк нь ХАА-н тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих бага хүүтэй зээлийг санал болгож эхэлсэн. Тухайлбал, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжийн бизнесийн үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад түлхэц болох эргэлтийн хөрөнгийн зээл болон тэдгээрийн үйлдвэрлэлийг дэмжих, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах зориулалттай хөрөнгө оруулалтын зээлүүдийг тус тус шинээр олгох болон дахин санхүүжүүлж эхэллээ. Мөн Цагаан алт, Атар-4, Шинэ хоршоо зэрэг засгийн газрын хөтөлбөрүүдийн хүрээнд системийн хэмжээнд 40%-ийн оролцоотойгоор төслийн зээлүүдийг олгож, санхүүжүүлж ажиллав.

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2025 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн шийдвэрээр банкнаас олгох хэрэглээний зээлийн өр орлогын харьцааны дээд хязгаарыг бууруулан 50 хувьд болгосон нь банкуудыг бизнесийн зээлд чиглүүлэх, ажил эрхлэлтийг дэмжих, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, зээлийн хэт өсөлтөөс сэргийлэх зэрэг ач холбогдолтой байна. Энэхүү шийдвэрүүдийн дагуу, ХААН Банк нь уламжлалт болон цахим сувгууд дээрх хэрэглээний зээл болон тэтгэврийн зээлийн бүтээгдэхүүнээ шинэчлэн харилцагчдадаа санал болгож эхэлсэн. 2025 оны 12 дугаар сард Мөнгөний бодлогын шийдвэрээр тэтгэврийн зээлийн хугацааг 36 сар болгон шинэчилсэнтэй холбоотой ХААН Банк нь тэтгэврийн зээлийн үлдэгдэлтэй харилцагчдадаа зээлийн үлдэгдэл хугацаагаа 36 сар хүртэл онлайнгаар сунгах боломжийг нэвтрүүлсэн.

Эх үүсвэрийн удирдлагыг сайжруулах чиглэлд, тайлант хугацаанд олон улс болон дотоодоос нийт 530 сая ам.долларын урт хугацаат санхүүжилт татан төвлөрүүлсэн ба үүний 30 тэрбум төгрөгийг дотоодын зах зээлээс буюу Жендер бондын санхүүжилт бүрдүүлэв. 2025 онд татсан нийт санхүүжилтийн 37% нь бичил болон ЖДБ, эмэгтэй бизнес эрхлэгчдийг санхүүжүүлэхэд, 34% нь тогтвортой ХАА-г санхүүжүүлэхэд, 28% нь ногоон төслийг санхүүжүүлэхэд тус тус зарцуулагдсан.

ХААН Банк нь эрсдэлийн удирдлагыг олон улсын жишигт нийцүүлэн хэрэгжүүлж, бизнесийн үйл ажиллагаанд “СТОУС S1 & S2, ICAAP, ILAAP” зэрэг санхүүгийн болон эрсдэлийн удирдлагын олон улсын стандартыг хэрэгжүүлэн ажилладаг ба ICAAP, ILAAP үнэлгээний тайланг бэлтгэн, зохицуулагч байгууллагад тайлагнаж, SREP үнэлгээгээр Шаардлага хангасан /3 оноо/ гэж үнэлэгдсэн. Үүний сацуу, Кибер эрсдэлд онцгой анхаарч мэдээллийн аюулгүй байдлын үйл ажиллагааны төлөвшлийн үнэлгээний дагуу үйл ажиллагааг хэрэгжүүлж, мэдээллийн аюулгүй байдлын үйл ажиллагааг “Bronze level” буюу Хүрэл түвшинд хүргэлээ.

Цахим банкны стратегийн хүрээнд харилцагчдад дэлхийн жишигт нийцсэн шинэ технологи, цахим бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэхийн зэрэгцээ системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангахад онцгой анхаарч, 2025 онд системийн бэлэн байдлыг 99.9 хувьтай ханган ажиллав. Банкны арын үйл ажиллагааг автоматжуулах, мэдээлэл технологийн дэд бүтцийг сайжруулах, системүүдийг шинэчлэх ажлуудыг тасралтгүй хэрэгжүүлж, харилцагчид хүрэх үйлчилгээний хурд, хүртээмжтэй найдвартай байдлыг нэмэгдүүлсэн. Өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих зорилгоор машин сургалт, хиймэл оюунд суурилсан “DigiBrain” системийг нэвтрүүлж, харилцагчийн хэрэгцээ, зан төлөвт нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг тохирох сувгаар санал болгох боломжийг бүрдүүлсэн. Мөн цахим стратегийн хэрэгжилтийг эрчимжүүлж, зээл, депозит, карт зэрэг үндсэн бүтээгдэхүүн үйлчилгээг бүрэн цахимжуулан, салбар нэгжид биечлэн авах шаардлагатай байсан үйлчилгээг цахим орчинд шилжүүлснээр зах зээл дэх өрсөлдөх чадвар, үйлчилгээний стандарт, хүртээмжийг нэмэгдүүлсэн. Цахим төлбөр тооцооны экосистемийг хөгжүүлэх хүрээнд Digi Pay аппликейшнийг тасралтгүй шинэчилж, харилцагчийн өдөр тутмын хэрэглээнд нийцсэн функцүүдийг нэвтрүүлэн, тоглоомчилсон лоялти хөтөлбөрийг хэрэгжүүлснээр төлбөр тооцооны идэвхжил, харилцагчийн оролцоог нэмэгдүүлж байна. Үүний зэрэгцээ процесс автоматжуулалтын технологийг байгууллагын хэмжээнд нэвтрүүлж, процессын нэгдсэн сан бүрдүүлэн нарийвчилсан шинжилгээ, автоматжуулалтыг хэрэгжүүлсний үр дүнд 104 мянга гаруй цагийн гар ажиллагааг автоматжуулж, үйл ажиллагааны үр ашгийг бодитоор нэмэгдүүлсэн. Generative-AI технологид суурилсан “Business AI туслах” системийг нэвтрүүлснээр ажилтнууд болон харилцагчид 24/7 горимоор мэдлэг, мэдээлэл

авах боломжтой болж, бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалт, харилцагчийн туршлагыг сайжруулах суурь бүрдсэн.

Байгууллагын хөгжлийн зорилгын хүрээнд 2025 онд хүний нөөц, соёл, бүтээмж, цахим шилжилт, манлайллыг хамарсан бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, тогтвортой өсөлт, өрсөлдөх чадварыг бэхжүүлэхэд чиглэн ажилласан. Ажилтнуудын ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх зорилгоор олон улсын цахим сургалтын платформуудыг нэвтрүүлж, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт, цахим ур чадварыг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулсан бөгөөд ажилтны туршлага, байгууллагын соёлыг бэхжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэн уян хатан, хүн төвтэй ажлын орчныг бүрдүүлсэн. Түүнчлэн чадамжид суурилсан карьер хөгжлийн тогтолцоог бүрдүүлж, ажилтнуудын ур чадварын зөрүүг тодорхойлон хөгжүүлэх, тасралтгүй суралцах соёлыг төлөвшүүлэх, манлайллын болон мэргэжлийн чадамжийг системтэйгээр нэмэгдүүлэх замаар байгууллагын ирээдүйн чадавхыг бэхжүүлэн ажиллаж байна.

Тогтвортой хөгжлийн чиглэлд банк нь “Тогтвортой байдлын стратеги 2030” болон “Тогтвортой хөгжлийн бодлого”-ыг шинэчлэн баталж, байгаль орчин, нийгэм, засаглал болон хариуцлагатай банкны зарчмуудыг үйл ажиллагаанд нэгтгэн хэрэгжүүлэх засаглалын тогтолцоог бүрдүүлсэн. Давхар материаллаг байдлын үнэлгээнд үндэслэн тодорхойлсон тэргүүлэх асуудлуудыг стратеги, эрсдэлийн удирдлага, бүтээгдэхүүн үйлчилгээ, санхүүжилтийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлж, БОНЗ-ын эрсдэл, боломжийг системтэй удирдах, ил тод тайлагнах, урт хугацааны үнэ цэнийг бий болгох чиглэлд бодит ахиц гаргасан. Үүний зэрэгцээ тогтвортой санхүүжилтийн хүрээнд ногоон болон нийгмийн зээлийн бүтээгдэхүүнүүдийг хөгжүүлж, зах зээлд эзлэх байр сууриа хадгалан, ногоон зээлийн багцын өсөлтийг ханган ажилласан. Ийнхүү байгууллагын хөгжил, тогтвортой байдлын бодлого, хүний нөөцийн чадавх, нийгмийн хариуцлагын санаачилгуудыг уялдуулан хэрэгжүүлснээр ХААН Банк нь гадаад, дотоод орчны өөрчлөлтөд дасан зохицох, оролцогч талуудад урт хугацааны үнэ цэнэ бий болгох суурийг бэхжүүлэн ажиллаж байна.

2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл
------	--

Банкны жилийн санхүүгийн аудитлагдсан тайлангийн 64-72 дугаар хуудаснаас харна уу.

2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;
------	--

Тайлант хугацаанд Банк нь олон улсын болон дотоодын зах зээлээс урт хугацаат, барьцаагүй зээл болон өрийн хэрэгслийн хэлбэрээр нийт 530.0 сая ам.долларын санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлсэн. 2025 онд татан төвлөрүүлсэн дээрх санхүүжилтээс эргэн төлөлт хийгдээгүй байна.

Түүнчлэн 2025 оноос өмнөх жилүүдэд татан төвлөрүүлсэн санхүүжилтээс 172.9 сая ам.долларын эргэн төлөлтийг хийж гүйцэтгэсэн. Тайлант хугацааны эцсийн байдлаар нийт санхүүжилтийн үлдэгдэл 1,166.0 сая ам.долларт хүрсэн байна.

3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл
----	--

Монгол Улсын Компанийн тухай хууль болон Банкны “Ашиг сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцэл хийх бодлого”-д заасны дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх эсэх шийдвэрийг Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-өөс гаргана. Тухайн шийдвэрийг сонирхлын зөрчилгүй ТУЗ-ийн гишүүдийн олонхын саналаар батлах бөгөөд шийдвэр гаргах үйл явцад ТУЗ-ийн хараат бус гишүүд бүгд оролцож, саналаа өгдөг. Ийнхүү Банк нь стратегийн болон үйл ажиллагааны зорилтоо хэрэгжүүлэх явцад үүсэж болзошгүй ашиг сонирхлын зөрчлийг зохистойгоор удирдан, хувьцаа эзэмшигчид болон харилцагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалан ажиллаж байна.

Тайлант хугацаанд Банкны эзэмшигч болон эрх бүхий албан тушаалтантай холбоотой нийт 50.4 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 30 хэлцлийг ТУЗ-өөр хэлэлцүүлэн, холбогдох хууль тогтоомж, дотоод бодлого

журмын дагуу шийдвэрлэж, мэдээллийн ил тод байдлыг ханган олон нийтэд тухай бүр мэдээлж ажилласан болно.

ХААН Банк нь тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл хийгээгүй болно.

4.	Цалин урамшууллын мэдээлэл
-----------	-----------------------------------

Монгол Улсын Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо (“СЗХ” гэх)-ны “Компанийн засаглалын кодекс”, Банкны Дүрэмд заасны дагуу ТУЗ-ийн гишүүдийн цалин хөлсний хэмжээг тогтоох асуудлыг зөвхөн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэдэг.

ТУЗ-ийн 2025 оны зардлын төсвийг 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн баталсан. ТУЗ-ийн зардлын төсөвт ТУЗ-ийн дарга болон ТУЗ-ийн гишүүдийн цалин хөлс болон ажил олгогч хуулийн этгээдийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн зардал зэрэг багтдаг.

ХААН Банкны Хүний нөөцийн бодлогын 4 дүгээр бүлэгт цалин хөлсний бүтэц, үндсэн цалин ба түүний хэмжээг тогтоох, хэрхэн нэмэгдүүлэх талаар тусгасан. Тус бүлэгт Монголын банкны системийн өрсөлдөөнт нөхцөл байдлыг харгалзан ХААН Банк нь бусад өрсөлдөгч банкны ажилтнууддаа олгож буй цалингийн түвшинтэй дүйцэхүйц, тэдгээрээс арай өндөр түвшинд цалин хөлс тогтоохыг эрмэлзэхээр заасан. Түүнчлэн үндсэн ажилтны цалингийн хэмжээг тогтоохдоо гадаад зах зээлийн цалингийн түвшин, албан тушаалын түвшин, зэрэглэл, ажилтны ур чадвар, мэргэшсэн байдал, гадаад хэлний мэдлэг, банкны бизнесийн хэрэгцээ, эдийн засгийн боломж болон инфляц, амьжиргааны өртгийн түвшин зэргийг харгалзан үзнэ.

Банкны Гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийг үнэлэхдээ ТУЗ-өөр батлагдсан санхүүгийн болон санхүүгийн бус бизнес зорилтуудын шалгуур үзүүлэлтүүдэд үндэслэдэг. Эдгээр бизнес зорилтуудын хэрэгжилтийг ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, Хүний нөөцийн хороо улирал тутам хянаж, Банкны жилийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан гарсны дараа тайлант жилийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг хийдэг.

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, Хүний нөөцийн хорооноос Гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийг үнэлж, ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, Цалин урамшууллын хорооноос гаргасан саналын дагуу ТУЗ нь Гүйцэтгэх удирдлагад олгох үндсэн цалин, урамшууллын хэмжээг тогтоодог. Ийнхүү тогтоохдоо ХААН Банкны Цалин хөлсний журмын дагуу дараах зарчмуудыг үйл ажиллагаандаа мөрддөг. Үүнд:

1. Эрх тэгш, шударга байх;
2. Өрсөлдөхүйц байх;
3. Хуульд нийцсэн байх;
4. Цалин хөлс олгох ажиллагаа ил тод байх;
5. Нууцлалтай байх;
6. Ажлын байрны зэрэглэл, гүйцэтгэлд нийцтэй байх.

5.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл
-----------	---

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Компанийн засаглал нь компанийн удирдлага, Төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын харилцаа, хамтын ажиллагааг удирдах, чиглүүлэх, хяналт тавих цогц тогтолцоо юм. Компанийн засаглалын бүтэц, түүний үйл ажиллагаа тогтвортой, сайн байх нь компани бие даасан, хараат бус байх, ирээдүйн хөгжилд тууштай анхаарах нөхцөлийг бүрдүүлж, олон эерэг үр дүнг бий болгох давуу талтай.

ХААН Банк нь компанийн засаглалтай холбоотой Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, сайн туршлагуудыг дотооддоо нэвтрүүлэх замаар хөрөнгө оруулагч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, урт хугацаанд тогтвортой үнэ цэн бүтээхэд анхаарч ажилладаг. Ингэснээр олон улсын үнэлгээний агентлагуудын дунд компанийн үнэлгээг өсгөх, Монголдоо системийн нөлөө бүхий тэргүүлэгч банкны нэр хүндийг хадгалах, урт хугацаанд тогтвортой хөгжихөд ач холбогдолтой.

Олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хувьд бид олон улсын сайн туршлагаас суралцан засаглалын тогтолцоогоо тасралтгүй сайжруулан, холбогдох хууль, дүрэм журмуудын хэрэгжилтийг хангаж компанийн засаглалаар тэргүүлсэн, үлгэр жишээ компани болохыг зорьж байна.

Банк нь Монгол Улсын Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Монголбанкнаас баталсан “Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журам”, СЗХ-ноос баталсан “Компанийн засаглалын кодекс”, “Монголын хөрөнгийн бирж” ХК (“МХБ” гэх)-иас баталсан “Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам”, ХААН Банкны Дүрэм, ХААН Банкны Компанийн засаглалын кодекс болон бусад холбогдох хууль тогтоомжийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгодог

ХААН Банкны Компанийн засаглалын кодексийн дагуу дараах компанийн засаглалын 4 зарчмийг үйл ажиллагаандаа баримталдаг. Үүнд:

- Хариуцлагатай байдал – Банк хууль ёсныхоо эрх ашгийн хүрээнд өөрт олгогдсон хэрэгжүүлж буй эрх мэдэл болон үүргээ бүрэн хариуцах хариуцлагатай байх
- Ил тод байдал – Мэдээллийн нээлттэй, хүртээмжтэй, тодорхой байдлыг хангаж, оролцогч талуудад шийдвэр, үйл ажиллагааг ойлгож, итгэх боломжийг олгох
- Тайлагнал – Банкны бүх оролцогч /сонирхогч талуудад албан ёсны баримт бичиг, мэдэгдэл, харилцаагаар дамжуулан мэдээллийг тодорхой зохион байгуулалттайгаар хүргэх
- Шударга байдал – Банкны бүх оролцогч болон сонирхогч талуудад шударга, тэгш, ялгаваргүй хандах

Компанийн засаглалын үнэлгээ

Монгол Улсын Компанийн тухай хууль, СЗХ-ноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-т заасан компанийн засаглалын зарчмуудын дагуу Банк нь өөрийн засаглалын үнэлгээг тогтмол хугацаанд хийж, СЗХ-гоор хянан баталгаажуулдаг.

ХААН Банкны Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайланг 2025 оны жилийн эцсийн байдлаар СЗХ хянан баталгаажуулж 98.6 оноо буюу засаглал сайн, эрсдэлгүй гэж үнэлсэн. Энэхүү үнэлгээ нь компанийн засаглалын чанар, хяналт, удирдлагын тогтолцоог бид үр дүнтэй хэрэгжүүлж буйг илэрхийлж байна. Энэхүү үнэлгээний өсөлт нь дотоод хяналтын тогтолцоо, эрсдэлийн удирдлага, ёс зүйн дүрэм, удирдлагын шийдвэр гаргалтын ил тод байдлыг улам бүр бэхжүүлсний үр дүн юм. Цаашид компанийн засаглалын тогтолцоог улам сайжруулах, харилцагч болон хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр тасралтгүй анхаарч ажиллах зорилт тавиад байна.

Засаглалын бодлого, журмууд

1. Банкны Дүрэм
2. Банкны Компанийн засаглалын кодекс
3. Банкны Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам
5. ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, Цалин урамшууллын хорооны дүрэм
6. ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, Хүний нөөцийн хорооны дүрэм
7. ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хорооны дүрэм
8. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүрэм
9. ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журам
10. Төлөөлөн удирдах зөвлөлийн Ажлын албаны үйл ажиллагааны бодлого
11. Хөрөнгө оруулагчидтай харилцах бодлого
12. Ногдол ашгийн бодлого
13. Дотоод мэдээлэл эзэмшигчийн арилжааны бодлого
14. Шүтэл үлээх бодлого
15. Ашиг сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцэл хийх бодлого
16. Мэдээллийн ил тод байдал, мэдээллийг толилуулах бодлого

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт ХААН Банкны эрх барих байгууллага нь ТУЗ бөгөөд үйл ажиллагаа явуулах хэлбэр нь ТУЗ-ийн хурал байна. ТУЗ нь Банкны Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.13-т заасан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг.

ХААН Банкны ТУЗ нь компанийн зорилго, зорилтоо биелүүлэхэд чиглэсэн алсын хараа, стратеги, үйл ажиллагааг чиглүүлэх, удирдах, хяналт тавин ажилладаг. ТУЗ нь Монгол Улсын Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Биржийн холбогдох дүрэм, журам, заавар, ХААН Банкны Дүрэм, Компанийн Засаглалын Кодекс, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон бусад холбогдох эрх зүйн баримт бичгийг мөрдөн, компанийн зохистой засаглалыг хэрэгжүүлэн үйл ажиллагаа явуулдаг.

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

ХААН Банкны ТУЗ нь банк, санхүү, эрсдэлийн удирдлага, компанийн засаглал, хууль эрх зүй, зохицуулалтын орчин болон стратеги төлөвлөлт зэрэг чиглэлээр мэргэшсэн, нэр хүнд бүхий олон улсын болон Монгол Улсын банк санхүүгийн салбарын арвин туршлагатай, хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл болон хараат бус гишүүдээс бүрдсэн нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг 2023 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар 3 жилийн хугацаатай томилсон бөгөөд Банкны тухай хуулийн 33.1, ХААН Банкны Дүрмийн 9.1-т заасны дагуу нийт гишүүдийн гуравны нэг (1/3) нь хараат бус гишүүдээс бүрдэж байна.

ТУЗ-ийн хараат бус гишүүд

- Т.Дарьбум – ТУЗ-ийн дарга

Хатагтай Т.Дарьбум 2020 оны 8-р сараас ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр Монгол Улс болон Хойд Америкт бизнесийн удирдлага, банк санхүүгийн чиглэлээр 30 гаруй жил ажилласан, өндөр ур чадвартай мэргэшсэн хүн юм. Хойд Америкийн зургаа дахь, Канад Улсын хоёр дахь том банк болох “ТиДи банк” группт 10 гаруй жил ажилласан туршлагатай бөгөөд АНУ-ын Сиаттлын их сургуульд санхүүгийн шинжлэх ухааны магистрын зэрэг хамгаалсан. Канадын мэргэшсэн нягтлан бодогч (CPA) зэрэгтэй.

- А.Тамир

Монголын мэргэшсэн татварын зөвлөх, Монголын мэргэшсэн нягтлан бодогч (CPA) ноён А.Тамир нь 2020 оны 7-р сараас Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр аудит, нягтлан бодох бүртгэл, татварын болон санхүүгийн тайлан, дүн шинжилгээ, бизнес төлөвлөлт гэх зэргээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг олон улсын “Пи Кэй Эф Интернэйшнл” компанийн Монгол дахь гишүүн компани болох “Пи Кэй Эф - Ай Эф Эс Монголиа” ХХК-ийн үүсгэн байгуулагч, Ерөнхий захирлын үүрэг гүйцэтгэдэг.

- Ханс Аарт Йонгеянс

Ноён Ханс Аарт Йонгеянс нь 2020 оны 7-р сараас банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр банк санхүүгийн салбарын эрсдэлийн удирдлагын чиглэлээр 50 гаруй жил ажилласан туршлагатай бөгөөд Нидерландын Вант улсын Банк санхүүгийн институтийг амжилттай дүүргэн Эй Би Эн АМРО банк (Нидерланд), Би Эн Пи Парибас банк (Франц) болон Австрали, Тайланд, Бельги, Саудын Араб, Бахрейн зэрэг улсын банк санхүүгийн байгууллагад удирдах албан тушаал хашиж байсан.

ТУЗ-ийн ердийн гишүүд

- Д.Хулан – ТУЗ-ийн дэд дарга

Хатагтай Д.Хулан нь банкны бие даасан хувьцаа эзэмшигч бөгөөд ТУЗ-ийн гишүүнээр 2003 оны 3-р сараас ажиллаж байна. Тэрээр “Таван Богд” группийг үүсгэн байгуулагчдын нэг бөгөөд ТУЗ-ийн даргын албан тушаалыг хашдаг. Д.Хулан нь ОХУ-ын Москва хотын Санхүүгийн их сургуулийг олон улсын эдийн засгийн бакалавр зэрэгтэй төгссөн, мөн Япон улсад мэргэжил дээшлүүлсэн. Түүнчлэн Монгол Улсын Сангийн яам,

Худалдаа хөгжлийн банк зэрэг байгууллагад ажиллаж байсан, банк санхүүгийн салбарын арвин мэдлэг, туршлагатай.

■ **Иший Кисабүро**

Ноён Иший Кисабүро нь “Эйч Эс Холдингс” ХК-ийг төлөөлсөн ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд тус компанийн хараат бус захирлаар ажиллаж байна. Тэрээр Токиогийн их сургуулийг эрх зүйн бакалаврын зэрэгтэй төгссөн. Япон улсын Газар, дэд бүтэц, тээврийн яамнаас ажлын гараагаа эхлүүлж, Хотын захиргааны ерөнхий захирлаас дэд сайдын албан тушаал хүртэл дэвшин ажилласан. Түүнчлэн Япон улсаас Румын улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдын албан тушаалыг хашиж байсан туршлагатай.

■ **Ц.Баатарсайхан**

Ноён Ц.Баатарсайхан нь “Таван Богд Холдингс” ХХК-ийг төлөөлсөн ТУЗ-ийн гишүүн юм. Тэрээр ТУЗ-ийн ердийн гишүүнээр 2009 оны 3-р сараас томилогдон ажиллаж байна. “Таван Богд” группийн үүсгэн байгуулагчдын нэг бөгөөд Ерөнхийлөгчийн албан тушаалыг хашдаг. Ц.Баатарсайхан нь Монгол Улсын Политехникийн их сургууль болон Япон улсын Токио хотын Цахилгаан холбооны их сургуулийг тус тус дүүргэсэн. Монгол-Японы хамтарсан “Алтай” ХХК-ийн захирал болон МИАТ ХК-ийн дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байсан туршлагатай.

■ **Харада Ясүнари**

Ноён Харада Ясүнари нь “Эйч Эс Интернэйшнл (Ази)” компанийг төлөөлсөн ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд “Эйч Эс Холдингс” ХК-ийн Ерөнхийлөгч, Төлөөлөгч захирлын албан тушаалыг хашиж байна. Тэрээр Япон улсын Кьюшү их сургуулийг Эрх зүйн бакалаврын зэрэгтэй төгссөн. Ажлын гараагаа Япон улсын Аж үйлдвэрийн банкнаас эхлүүлж, Морган Стэнли, Би Эн Пи Парибас, Социэтэ Женерале зэрэг олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын Япон Улс дахь салбаруудад ажиллаж, туршлага хуримтлуулсан.

■ **Жон Ло**

Ноён Жон Ло нь байгууллагын банк болон хөрөнгө оруулалтын банкны чиглэлд 30 гаруй жил ажилласан арвин туршлагатай нэгэн. Өмнө нь ОУСК-ийн Олон улсын санхүүгийн зах зээлийн газарт банкны мэргэжилтнээр ажиллаж байсны дээр СитиБанк болон Жи.Пи Морган зэрэг банкуудад Ази, Номхон далайн бүс хариуцсан удирдах түвшний албан тушаал хашиж байсан туршлагатай. Тэрээр АНУ-ын Индиана мужийн Блүүмингтон хот дахь Индианагийн их сургуульд Бизнесийн удирдлагын чиглэлээр магистрын зэрэг хамгаалсан. 2016 оноос ХААН Банкны ТУЗ-ийн ердийн гишүүнээр томилогдон ажиллаж байна.

■ **Б.Амарсанаа**

Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал, Хууль зүйн ухааны доктор, профессор Батболдын Амарсанаа нь банкны ТУЗ-ийн ердийн гишүүн юм. Тэрээр өмнө нь Арбитрын шүүхийн арбитрч, шүүн таслах бүрэлдэхүүний даргаар олон хэрэг дээр ажиллаж байсан төдийгүй Хонконгийн Олон улсын арбитрын төв, Олон улсын худалдааны танхимын арбитрын шүүх дээр Монгол Улсын хууль эрх зүйн мэргэжилтнээр ажиллаж маргаан шийдвэрлэж байсан туршлагатай. Үүнээс гадна Хууль зүйн зөвлөлийн үндсэн гишүүний хувьд Монгол Улсын томоохон хуулиудын төслийг бэлтгэх чиглэлээр ажилласан өргөн туршлагатай хүн юм.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал

ТУЗ нь жилийн эхэнд баталсан бүтэн жилийн хуваарьт заасан өдрүүдэд улиралд нэг (1)-ээс доошгүй удаагийн давтамжтайгаар тогтмол хуралддаг бөгөөд шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулдаг. Тайлант хугацаанд ТУЗ нь гишүүдийн 100 хувийн ирцтэйгээр нийт 7 удаагийн хурал, 34 удаагийн цахим санал хураалт явуулсан байна. 2025 онд нийт 81 асуудлыг хэлэлцсэн бөгөөд 44 тогтоолыг баталсан болно.

№	2025 онд ТУЗ-ийн хэлэлцсэн асуудлууд
1.	Стратегийн түвшинд удирдан чиглүүлэх - Тогтвортой байдлын стратеги - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлах

	- Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах - Монголын хөрөнгийн зах зээлд Жендэр Бонд гаргах - Олон улсад хаалттай хүрээнд Ногоон Бонд гаргах 2025 оны Тогтворжуулах төлөвлөгөө 2024 оны Үйл ажиллагааны тайлан 2024 оны жилийн эцсийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан 2024 оны Өөрийн хөрөнгийн хүрэлцээг дотооддоо үнэлэх үйл явц болон Хөрвөх чадварын хүрэлцээг дотооддоо үнэлэх үйл явцын тайлан - Эрсдэлийн сангаас хорогдуулсан чанаргүй актив 2026 оны Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдэл 2026 оны Бизнес төлөвлөгөө 2026 оны Санхүүгийн төсөөлөл 2026 оны Капитал хөрөнгийн зардал 2026-2030 оны Дунд хугацааны санхүүгийн төсөөлөл
2.	Зохистой хяналт, засаглалын тогтолцоо - ТУЗ-ийн Аудитын хорооны шинэчилсэн дүрэм - ТУЗ-ийн Эрсдэлийн хорооны шинэчилсэн дүрэм - ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журам - Тогтвортой байдлын бодлого - Мөнгө угаах болон санхүүгийн гэмт хэргийн эсрэг баримтлах бодлого - Хориг арга хэмжээний бодлого - Залилангийн удирдлагын бодлого - Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөр - Байгууллагын нэгдсэн эрсдэлийн удирдлагын бодлого - Дотоод хяналтын бодлого
3.	Бусад “ХААН Банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах шинэчилсэн төлөвлөгөө - ТУЗ-ийн жилийн сургалтын хөтөлбөр - Монголын ногоон санхүүгийн корпорацид санхүүжилт олгох - Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий албан тушаалтан - Гүйцэтгэх захирлын цалин, урамшуулал - Олон улсын зээлдүүлэгч байгууллагуудаас татсан санхүүжилтүүд – ЕСБХБ, АХБ, FinDev Canada, BlueOrchard - Сонирхлын зөрчилтэй болон томоохон хэмжээний хэлцлүүд

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод

ХААН Банкны ТУЗ нь Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлд заасны дагуу Банкны зарим чухал үйл ажиллагааны чиглэлүүдэд тусгайлсан хяналт, шалгалтыг нэмэгдүүлж, ажлын үр дүнг сайжруулах зорилгоор дэргэдээ тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороодыг байгуулан ажиллуулдаг. ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг ТУЗ-ийн 2024 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 07 тоот тогтоолын дагуу шинэчлэн тогтоосон.

ТУЗ нь Аудитын хороо, Эрсдэлийн хороо, Засаглал, Цалин урамшууллын хороо болон Нэр дэвшүүлэх, Хүний нөөцийн хороо гэсэн нийт 4 байнгын хороотой бөгөөд хороод нь ТУЗ-өөс баталсан тус бүрийн дүрмээр зохицуулагддаг. Уг дүрмүүдэд хороодын бүрэн эрх, чиг үүрэг, хараат бус байдал, мөн хурал хуралдах журам зэрэг асуудлыг нарийвчлан зохицуулсан байдаг.

ТУЗ-ийн хараат бус байдлыг ханган ажиллахын хүрээнд ТУЗ-ийн дарга болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын даргаар хараат бус гишүүдийг сонгон ажиллуулж, мөн хороо бүрийн гишүүдийн гуравны хоёр (2/3)-ыг хараат бус гишүүдээс бүрдүүлэн ажиллаж байна.

• Аудитын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь Дотоод аудит болон хөндлөнгийн аудитын гүйцэтгэл, үр дүн, хараат бус байдалд хяналт тавих; Банкны дотоод хяналтын тогтолцооны үр дүнтэй байдал болон санхүүгийн тайлан ба нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв, бодит байдалд хяналт тавих зэрэг байдлаар ТУЗ-д дэмжлэг үзүүлэн ажилладаг.

Бүрэлдэхүүн	Хурлын тоо	Гишүүдийн ирц	Хэлэлцсэн гол асуудлууд
А.Тамир (дарга, хараат бус гишүүн)	4	100% (хурал тус бүр)	Банкны санхүүгийн тайлан, дүрэм, журам: - Дотоод аудитын 2024 оны ажлын гүйцэтгэл - Дотоод аудитын 2021-2024 оны Дунд хугацааны стратеги төлөвлөгөөний гүйцэтгэл - Дотоод аудитын 2025-2027 оны Дунд хугацааны стратеги төлөвлөгөө - Дотоод аудитын гүйцэтгэсэн Банкны 2025 оны Тогтворжуулах төлөвлөгөөний баталгаажуулалтын тайлан - Дотоод аудитын 2025 оны 1 дүгээр хагас жилийн гүйцэтгэлийн тайлан - Дотоод аудитын 2026 оны төлөвлөгөө - Дотоод аудитын дүрэм
Ханс Аарт Йонгеянс (хараат бус гишүүн)		100% (хурал тус бүр)	Дотоод аудит: - Дотоод аудитын 2024 оны ажлын гүйцэтгэл - Дотоод аудитын 2021-2024 оны Дунд хугацааны стратеги төлөвлөгөөний гүйцэтгэл - Дотоод аудитын 2025-2027 оны Дунд хугацааны стратеги төлөвлөгөө - Дотоод аудитын гүйцэтгэсэн Банкны 2025 оны Тогтворжуулах төлөвлөгөөний баталгаажуулалтын тайлан - Дотоод аудитын 2025 оны 1 дүгээр хагас жилийн гүйцэтгэлийн тайлан - Дотоод аудитын 2026 оны төлөвлөгөө - Дотоод аудитын дүрэм
Иший Кисабүро (ердийн гишүүн)		100% (хурал тус бүр)	Дотоод аудит: - Дотоод аудитын 2024 оны ажлын гүйцэтгэл - Дотоод аудитын 2021-2024 оны Дунд хугацааны стратеги төлөвлөгөөний гүйцэтгэл - Дотоод аудитын 2025-2027 оны Дунд хугацааны стратеги төлөвлөгөө - Дотоод аудитын гүйцэтгэсэн Банкны 2025 оны Тогтворжуулах төлөвлөгөөний баталгаажуулалтын тайлан - Дотоод аудитын 2025 оны 1 дүгээр хагас жилийн гүйцэтгэлийн тайлан - Дотоод аудитын 2026 оны төлөвлөгөө - Дотоод аудитын дүрэм

• Эрсдэлийн хороо

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороо нь Банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийн төлөв, гүйцэтгэлийг хүлээн зөвшөөрөх эрсдэлтэй харьцуулж хянах чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь ТУЗ-д дэмжлэг үзүүлэх; гол эрсдэлүүдийг тодорхойлох, хэмжих, хянах, бууруулах үйл ажиллагаанд хяналт тавих; гол эрсдэлүүдэд өртөх байдлыг хянах үүднээс бодлогын баримт бичгүүд, эрсдэлийн лимитүүдийг хянах, батлах; болон Банкны эрсдэлийн удирдлагын чиг үүргийг хянах, хэрэгжилтийг ханган ажилладаг.

Бүрэлдэхүүн	Хурлын тоо	Гишүүдийн ирц	Хэлэлцсэн гол асуудлууд
-------------	------------	---------------	-------------------------

Т.Дарьбум (дарга, хараат бус гишүүн)	7	100% (хурал тус бүр)	Эрсдэлийн удирдлага, бодлого журам: - ТУЗ-ийн Эрсдэлийн хорооны шинэчилсэн дүрэм - Мөнгө угаах болон санхүүгийн гэмт хэргийн эсрэг баримтлах бодлого - Хориг арга хэмжээний бодлого - Залилангийн удирдлагын бодлого, Залилангийн удирдлагын хөтөлбөр - Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөр - Дотоод хяналтын бодлого - Байгууллагын эрсдэлийн удирдлагын бодлого 2026 оны Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдэл Эрсдэл, комплаенсийн хяналт, тайлан: 2024 оны Өөрийн хөрөнгийн хүрэлцээг дотооддоо үнэлэх үйл явц (ICAAP)-ын тайлан болон Хөрвөх чадварыг дотооддоо үнэлэх үйл явц (ILAAP)-ын тайлан - Банкны 2025 оны Тогтворжуулах төлөвлөгөө 2025 оны эрсдэлийн сангаас хаах чанаргүй зээлүүд - Эрсдэл, комплаенсийн сар бүрийн тайлан
Ханс Аарт Йонгеянс (хараат бус гишүүн)		100% (хурал тус бүр)	
Ц.Баатарсайхан (ердийн гишүүн)		100% (хурал тус бүр)	

- Нэр дэвшүүлэх, Хүний нөөцийн хороо

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, Хүний нөөцийн хороо нь Банкны хүний нөөцийн стратеги, төлөвлөгөө, үндсэн бодлого, залгамж халаа, удирдлагын гэнэтийн бэлэн байдлыг удирдах, ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, ТУЗ-өөс томилогддог эрх бүхий албан тушаалтныг нэр дэвшүүлэх, томилох, үйл ажиллагаа, ажлын гүйцэтгэлд үнэлэлт дүгнэлт өгөхөд ТУЗ болон Хувьцаа эзэмшигчдийн хуралд дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Бүрэлдэхүүн	Хурлын тоо	Гишүүдийн ирц	Хэлэлцсэн гол асуудлууд
Ханс Аарт Йонгеянс (дарга, хараат бус гишүүн)	5	100% (хурал тус бүр)	Хүний нөөцийн стратеги: - Хүний нөөцийн стратегийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан - Хүний нөөц, Гүйцэтгэх удирдлагын улирал бүрийн гүйцэтгэлийн тайлан - Банкны нийт ажилтнуудын цалинг нэмэгдүүлэх санал - Эрх бүхий албан тушаалтны залгамж халааны төлөвлөгөө Нэр дэвшүүлэх, гүйцэтгэлийн үнэлгээ: - ТУЗ-ийн 2024 оны өөрийн үнэлгээний тайлан (ЗЦУХ-тай хамтран хэлэлцсэн) - Гүйцэтгэх захирлын 2024 оны ажлын гүйцэтгэлийн үнэлгээ (ЗЦУХ-тай хамтран хэлэлцсэн) - Гүйцэтгэх захирлын 2024 оны ажлын гүйцэтгэлийн урамшуулал (ЗЦУХ-тай хамтран хэлэлцсэн) - Гүйцэтгэх захирлын 2025 оны үндсэн цалин (ЗЦУХ-тай хамтран хэлэлцсэн) - Гүйцэтгэх захирлын 2025 оны ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөө (ЗЦУХ-тай хамтран хэлэлцсэн) 2025 оны ТУЗ-ийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний арга хэмжээний төлөвлөгөө
А.Тамир (хараат бус гишүүн)		100% (хурал тус бүр)	
Д.Хулан (ердийн гишүүн)		100% (хурал тус бүр)	

			2026 онд ТУЗ-ийн гишүүдийг томилох арга хэмжээний төлөвлөгөө
--	--	--	--

- Засаглал, Цалин урамшуулсан хороо

ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, Цалин урамшууллын хороо нь компанийн засаглалын цогц зарчим, ёс зүйн дүрэм, компанийн засаглалын стратеги, гүйцэтгэл, тайлагналд хяналт тавих, Банкны урамшууллын системийн зорилгыг тодорхойлох, ТУЗ болон ТУЗ-өөс томилогддог эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан олгох хүрээнд ТУЗ болон Хувьцаа эзэмшигчдийн хуралд дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Бүрэлдэхүүн	Хурлын тоо	Гишүүдийн ирц	Хэлэлцсэн гол асуудлууд
А.Тамир (дарга, хараат бус гишүүн)	5	100% (хурал тус бүр)	Засаглал, тогтвортой хөгжил: 2025 оны ТУЗ-ийн сургалтын төлөвлөгөө - ТУЗ-ийн 2024 оны өөрийн үнэлгээний тайлан (НДХНХ-тай хамтран хэлэлцсэн) - Тогтвортой байдлын стратеги - Тогтвортой байдлын бодлого - Монголбанк, СЗХ-ны засаглалын үнэлгээний тайлан - Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журам Цалин, урамшуулал: - ТУЗ-ийн 2025 оны зардлын төсөв - Гүйцэтгэх захирлын 2024 оны ажлын гүйцэтгэлийн үнэлгээ (НДХНХ-тай хамтран хэлэлцсэн) - Гүйцэтгэх захирлын 2024 оны ажлын гүйцэтгэлийн урамшуулал (НДХНХ-тай хамтран хэлэлцсэн) - Гүйцэтгэх захирлын 2025 оны үндсэн цалин (НДХНХ-тай хамтран хэлэлцсэн) - Гүйцэтгэх захирлын 2025 оны ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөө (НДХНХ-тай хамтран хэлэлцсэн)
Т.Дарьбум (хараат бус гишүүн)		100% (хурал тус бүр)	
Харада Ясүнари (гишүүн)		100% (хурал тус бүр)	

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

Банкны Гүйцэтгэх удирдлагыг Банкны Дүрмийн 13 дугаар зүйлийн 13.1-т заасны дагуу ТУЗ-өөс томилогдсон Гүйцэтгэх захирал дангаараа хэрэгжүүлдэг бөгөөд ингэхдээ ТУЗ-өөс тогтоосон эрх хэмжээний хүрээнд банкны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хяналт тавьж ажилладаг. Гүйцэтгэх захирлын өдөр тутмын болон шуурхай үйл ажиллагаа нь Удирдлагын хороогоор дамжин хэрэгждэг.

Удирдлагын хороо нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон зохицуулагч байгууллагуудын хууль ёсны шийдвэр, Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ-өөс гаргасан шийдвэр, тогтоолын хэрэгжилтийг хангуулах, зохион байгуулах зорилгоор банкны стратегийн зорилт, бизнес төлөвлөгөө, үндсэн үйл ажиллагаа болон бусад шаардлагатай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг болно. Хороо нь үндсэн чиг үүргийнхээ хүрээнд Монгол Улсын нийгэм, эдийн засаг, улс төр, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан асуудал хэлэлцэж, мэдээлэл солилцдог.

ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Дотоод аудитын зохион байгуулалт, чиг үүрэг

ХААН банкны дотоод аудит нь зохистой засаглалын зарчмын дагуу Банкны гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны шууд удирдлагад харъяалагдан ТУЗ-ын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Дотоод аудит нь Банкны эрсдэлийн удирдлагын хамгаалалтын III шугамын чиг үүргийн хүрээнд

Гүйцэтгэх удирдлагаас бий болгосон эрсдэлийн удирдлагын тогтолцоо, хамгаалалтын I болон II шугамын үр дүнтэй байдалд үнэлгээ хийж, зөвлөмж мэдээллээр хангаж байна.

ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь Ерөнхий аудиторын томилгоо, Дотоод аудитын дүрэм, стратеги болон жилийн төсөв төлөвлөгөөг батлах, аудитын гүйцэтгэл, үйл ажиллагаанд хяналт тавих байдлаар Дотоод аудитын бие даасан, хараат бус байдлын статусыг хангадаг. Ерөнхий аудитор нь Дотоод аудитын дүрмээр тодорхойлогдсон эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаагаа Салбарын аудитын газар, Төв банкны аудитын газар, Мэдээлэл технологийн аудитын газар гэсэн бүтэцтэйгээр зохион байгуулж, Банкны стратегид чиглэсэн бөгөөд эрсдэлд суурилсан арга аргачлалаар төлөвлөн хэрэгжүүлж байна.

Дотоод аудит нь үйл ажиллагаандаа Олон Улсын Дотоод Аудиторуудын Институт (ОУДАИ)-ээс гаргасан Олон Улсын Мэргэжлийн Практикийн Хүрээ (цаашид ОУМПХ гэх)-ний Стандартуудыг мөрдөж ажилладаг бөгөөд 2023 онд олон улсын нэр хүнд бүхий байгууллагаар Хөндлөнгийн чанарын баталгаажуулалт хийлгэж “бүрэн нийцдэг” үнэлэгдсэн. 2024 онд шинэчлэгдэн батлагдсан ОУМПХ-ний Стандартууд болон Сэдэвчилсэн шаардлагуудын хүрээнд 2025 онд дотоод аудитын дүрэм болон дагалдах баримт бичгүүдээ шинэчилсэн ба Стандартын нийцтэй байдалд жил бүр дотоод чанарын баталгаажуулалтын үнэлгээ хийж сайжруулдаг.

Дотоод аудит нь тодорхойлсон зорилго, стратеги түүнийг хэрэгжүүлэх засаглалын зохистой зохион байгуулалтаараа Банкны бизнесийн урт хугацааны тогтвортой үйл ажиллагааны зорилгыг дэмжих хамгаалахад чиглэн ажиллаж байна.

Дотоод аудитын зорилго, үйл ажиллагаа.

Банкны Дотоод аудит нь “Банкны Засаглал, Эрсдэлийн удирдлага, Хяналтын тогтолцоонд бодитой байх зарчимд тулгуурласан хараат бус аудитын үйлчилгээ үзүүлэх замаар Банкны үнэ цэнг хамгаалах, нэмэгдүүлэх” зорилготой үйл ажиллагаа явуулдаг.

2025 онд бид үйл ажиллагаагаа ОУ-ын жишигт нийцүүлэх, дэвшилтэт технологийг ашиглан чанарын үр дүнг тогтмол сайжруулах үүднээс “Дунд хугацааны стратеги 2025-2027”-г шинэчлэн боловсруулж, дотоод аудитын үйл ажиллагааны стандартын нийцлийг хадгалж, мэргэжлийн ур чадварыг сайжруулан, аудитын үйл ажиллагаанд тэргүүлэх арга аргачлалыг нэвтрүүлж, автоматжуулалтыг сайжруулах замаар дижитал хөгжлийн дараагийн түвшинд хүрсэн, үнэ цэнийг нэмэгдүүлэгч стратегийн түнш болох зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

Энэхүү стратегийн суурь болох мэргэжлийн ур чадвартай хүний нөөцийг бүрдүүлэх зорилтын хүрээнд дотоод аудиторуудаа тогтмол сургаж хөгжүүлэхэд анхаарч ажилласны үр дүнд 2025 оны байдлаар CIA, CISA, ESG аудитор, ISO/IEC 27001:2022 lead, Cobit 2019 design and Implementation, AML & CFT foundation level зэрэг нийт аудиторт эзлэх санхүү, дотоод аудит, БОНЗ, мэдээлэл технологийн чиглэлд ОУ-ын мэргэшлийн сертификаттай аудиторуудын тоо 20%, мөн ММНБ, ТМЗ, ҮЦЗЗ-д мэргэжлийн үйлчилгээ эрхлэх, Компанийн засаглалын зэрэг дотоодын мэргэшлийн сертификаттай аудиторын тоо нийт аудиторт 35% -ийг эзэлж байна.

Тайлант хугацаанд “Дотоод аудитын төлөвлөлтийн бодлого”-ын дагуу банкны стратеги, зорилтуудад уялдсан бөгөөд эрсдэлийн үнэлгээнд суурилсан аудитын төлөвлөгөөг боловсруулан банкны тогтвортой бизнес стратеги, түүний 4 үндсэн чиглэлд хамаарах гол зорилтуудын хэрэгжилт, байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцооны үр дүнтэй байдалд баталгаажуулалт хийж, бизнесийн болон процессын үр ашигт байдалд чиглэн ажилласан.

Монголбанкнаас боловсруулсан “Банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөр”-өөр тодорхойлсон “Банкны хяналт шалгалт зохицуулалтын арга хэрэгслийг ОУ-ын жишигт нийцүүлэх”, “МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх, ФАТФ-ын дараагийн үнэлгээнд бэлтгэх” зорилтуудын хүрээнд Банкны эрсдэлийн удирдлагын үйл явцад томоохон өөрчлөлтүүд хийгдэж байна. Эдгээр өөрчлөлт нь ирээдүйд учирч болзошгүй эрсдэлээ таньж мэдэх, удирдах чиглэлд хийгдэж байгаа ба болзошгүй эрсдэлийн магадлал, үр нөлөө, хүчин зүйлийн оновчтой тооцоололтод аудитын баталгаажуулалт хийх шаардлагыг хэрэгжүүлэн ажилласан.

Банкны дижитал стратегийн хүрээнд хэрэгжүүлж байгаа цахим бүтээгдэхүүн үйлчилгээ, процессын автоматжуулалтын чиглэлд мэдээлэл технологийн болон мэдээллийн аюулгүй байдал, өгөгдөл тайлагналын эрсдэлд чиглэсэн аудитыг гүйцэтгэж баталгаажуулав.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

ХААН Банк нь эрсдэлийн удирдлагын тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлэх, тайлагнах, хяналт тавих зорилгоор эрсдэлийн засаглалын тогтолцоог бүрдүүлэн ажиллаж, түүнийг бизнесийн цар хүрээ, стратеги, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлттэй уялдуулан тогтмол шинэчилж сайжруулдаг. ТУЗ нь байгууллагын нэгдсэн эрсдэлийн удирдлагын тогтолцоо, эрсдэлийн засаглал, эрсдэлийн соёлыг төлөвшүүлэх ерөнхий чиг үүргийг хэрэгжүүлж, Эрсдэлийн хорооны хамт байгууллагын нэгдсэн эрсдэлийн удирдлагын бодлого болон хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдлийг хянан баталж, эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр нөлөөнд хяналт тавин ажилладаг.

Банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь хүлээн зөвшөөрөх эрсдэл, эрсдэлийн засаглал, эрсдэлийн удирдлагын үйл явц болон тэдгээрийг хэрэгжүүлэх бодлого, журам, аргачлал, төлөвлөгөөнөөс бүрддэг. ХААН Банк нь олон улсын шилдэг туршлага, стандарт, зохицуулагч байгууллагаас баталсан эрх зүйн акт, шаардлагад нийцүүлэн эрсдэлийн удирдлагын тогтолцоог тасралтгүй сайжруулж, бизнесийн үйл ажиллагаатай нягт уялдуулан хэрэгжүүлж байна.

Банкны гол эрсдэлийн бүртгэл нь стратеги, бизнес болон үйл ажиллагааны түвшинд үүсэж болзошгүй эрсдэлүүдийг нэгдсэн байдлаар тодорхойлох, үнэлэх, хянах, удирдах, мониторинг хийх, тайлагнах үйл явцыг дэмжих суурь баримт бичиг, лавлагаа болдог. Эрсдэлийн бүртгэлд багтах эрсдэлийн төрөл, дэд төрөл, ангиллыг “Эрсдэлийн ангилал зүй”-д нарийвчлан тодорхойлсон байдаг.

Банк нь 2025 онд эрсдэлийн удирдлагын бодлого, стратегийн хүрээнд дараах гол ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Байгууллагын нэгдсэн эрсдэлийн удирдлагын тогтолцооны (ERMF) төлөвшлийн түвшин болон стратегийн зураглалыг тодорхойлох үнэлгээг хөндлөнгийн аудитын байгууллага “Эрнст энд Янг Монголия Аудит” ХХК-иар хийлгэлээ. Тус үнэлгээг эрсдэлийн засаглал, эрсдэлийн стратеги ба хүлээн зөвшөөрөх түвшин, эрсдэлийн соёл, эрсдэлийн үнэлгээ ба хэмжилт, эрсдэлийн удирдлага ба хяналт, эрсдэлийн тайлагнал ба дүн шинжилгээ, өгөгдөл ба систем гэсэн хамрах хүрээнд хийлгэж үнэлгээний үр дүн болон 2029 он хүртэл хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө бүхий стратегийн замын зураглалыг хүлээн авлаа.
- Эрсдэлийн удирдлагын ерөнхий бодлогыг шинэчлэн боловсруулж, ХААН Банкны Байгууллагын нэгдсэн эрсдэлийн удирдлагын бодлого болгон шинэчилж, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороо болон ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан ба тус бодлогын хавсралтаар “Эрсдэлийн ангилал зүй” болон “Байгууллагын эрсдэлийн соёлын стратеги” баримт бичгүүдийг шинээр боловсруулж батлуулсан. Мөн ХААН Банкны дотоод хяналтын бодлогод нэмэлт өөрчлөлт оруулж, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороо болон ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан бөгөөд тус бодлогын сайжруулалтын хүрээнд “Өргөтгөсөн хамгаалалтын гурван шугам”-ын загварыг нэвтрүүлж, эрсдэлийн удирдлага болон хяналтын үүрэг, хариуцлагын хуваарилалтыг илүү нарийвчлан тодорхойлсон.
- Банк нь эрсдэлийг үр дүнтэй хянаж, удирдах зорилгоор 2025 онд “Internal Process, Risk Monitoring System” (IPRMS) системийг шинээр нэвтрүүлсэн бөгөөд энэхүү системээр эрсдэлийг тодорхойлж бүртгэх, үнэлэх, арга хэмжээ авах, хянах, тайлагнахтай холбоотой Эрсдэлийн самбарын үйл явц болон эрсдэлийн хороодын шийдвэр гаргалтын үйл явцыг автоматжуулсан. Цаашид энэ систем нь эрсдэлийн тайлагналын ил тод байдлыг нэмэгдүүлэх, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх ач холбогдолтой юм.
- ХААН Банк нь цахим шилжилт болон банкны бизнесийн загварын өөрчлөлт, стратегитай уялдуулан шинэ төрлийн эрсдэлүүд болох Технологийн эрсдэл, Уур амьсгалын нөлөөллийн эрсдэлүүдийг анхааран үзэж, байгууллагын нэгдсэн эрсдэлийн удирдлагын хүрээнд үр дүнтэй удирдаж, хянах үе шаттай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүний хүрээнд ногоон эдийн засгийг дэмжих, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний зорилтод хувь нэмэр оруулах бодлого, чиглэлийн дагуу банк нь 2024

онд Олон улсын санхүүгийн корпорацтай (“ОУСК”) Төслийн үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж, уг гэрээний хүрээнд уур амьсгалын эрсдэлийн удирдлагын механизмыг бүрдүүлэх ажлыг үе шаттай эхлүүлсэн.

Энэхүү ажлын хүрээнд банкны одоогийн уур амьсгалын стратегид шинжилгээ хийх, түүнийг олон улсын стандарттай нийцүүлэх зөвлөмжүүдийг авах, банкны зээлийн багцын уур амьсгалын биет эрсдэлийн өртөлтийг үнэлэх, санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгарлыг тооцоолох, мөн уур амьсгалын эрсдэлийн удирдлагын үйл явцыг Банкны нэгдсэн эрсдэлийн удирдлагын үйл явцад нэгтгэх зэрэг голлох ажлууд хийгдэж дууссан. Цаашид банк нь тус ажлын үр дүнд үндэслэн уур амьсгалын шилжилтийн стратегиа тодорхойлох бөгөөд ОУСК-ийн зөвлөмж, үнэлгээний үр дүнд суурилсан арга хэмжээ, бодлого, үйл явцыг дараагийн үе шатуудад шат дараатайгаар боловсруулж, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

- **Компанийн засаглалын кодекс**

ХААН Банк нь тогтвортой үнэ цэн бүтээх зарчмын хүрээнд оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэж, тэдэнтэй урт хугацаанд хамтран ажиллах хариуцлагатай засаглалын соёлыг төлөвшүүлэн ажиллаж байна. Оролцогч талуудтай харилцах, хамтын ажиллагааг “ХААН Банк ХК-ийн Компанийн засаглалын кодекс”-оор зохицуулж, ТУЗ нь уг харилцаанд баримтлах бодлого, удирдамжийг батлан, оролцогч талуудын ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, зохистойгоор тэнцвэржүүлэх удирдлагыг хэрэгжүүлдэг. Банк нь оролцогч талууд болон хөрөнгө оруулагчдад бизнесийн үйл ажиллагаа, засаглалын тогтолцоо, санхүүгийн болон санхүүгийн бус гүйцэтгэл, хэтийн төлөвтэй холбоотой мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдлыг ханган ажилладаг бөгөөд энэ хүрээнд тогтвортой байдлын болон жилийн тайлангуудаар дамжуулан оролцогч талуудтай хамтран ажиллахад баримталж буй стратеги, гол анхаарах чиглэл, хэрэгжилтийн үр дүнг тогтмол тайлагнаж байна.

- **Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр**

“ХААН Банк ХК-ийн Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр” нь хөрөнгө оруулагч, харилцагчдын эрх ашгийг хамгаалах, урт хугацаанд тогтвортой үнэ цэн бүтээхэд чиглэсэн олон төрлийн зорилго, арга хэмжээг агуулдаг. Тус хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй гол зорилгууд нь, компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг хангах, хувьцаа эзэмшигчийн эрхийг хамгаалах, баталгаажуулах, ТУЗ болон Гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтны хариуцлагын тогтолцоог олон улсын жишигт хүргэх, тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах, эрсдэлийн удирдлагыг сайжруулах, дотоод аудит, хяналтын тогтолцоог сайжруулах, Банкны цалин, урамшууллын бодлогыг оновчтой тодорхойлох, Банкны ёс зүйн дүрмийг чанд мөрдөх юм. Бид тус хөтөлбөрөөр Банкны дотоод бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг СЗХ-ны "Компанийн засаглалын кодекс"-ийн зарчимд нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэхээр зорьж байна.

- **Хөрөнгө оруулагчидтай харилцах бодлого**

МХБ-д бүртгэлтэй нээлттэй хувьцаат компанийн хувьд Банк нь өөрийн удирдлага, үйл ажиллагаа, санхүүгийн байдал, хэтийн төлөв, алсын хараатай холбоотой мэдээллийг тодорхой, шударга, тэнцвэртэй байдлаар хүргэх үүргийг хэрэгжүүлдэг. Энэ хүрээнд “ХААН Банк ХК-ийн Хөрөнгө Оруулагчидтай Харилцах Бодлого”-ыг ТУЗ-өөс баталж, хэрэгжүүлтийг хангаж байна. Уг бодлогын зорилго нь хөрөнгө оруулагчид болон боломжит хөрөнгө оруулагчдыг хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангах, бусад оролцогч талуудад Банк болон түүний стратеги, зорилгын талаар тэнцвэртэй ойлголт хүргэх юм. Хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр хэлэлцэх асуудлын хүрээнд холбогдох тайлан, мэдээллийг танилцуулж, санал авах, асуулга зохион байгуулахын зэрэгцээ цахимаар болон биечлэн санал, хүсэлт, өргөдөл, гомдол хүлээн авдаг. Түүнчлэн Банкны болон МХБ-ийн цахим хуудсууд, албан ёсны сувгууд, бусад холбогдох арга хэрэгслээр дамжуулан мэдээлэл солилцож, Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын дүрэм, журам, Банкны Дүрэмд нийцүүлэн хөрөнгө оруулагчидтай харилцаж байна.

- **Мэдээллийн ил тод байдал, мэдээллийг толилуулах бодлого**

ХААН Банк нь тогтвортой, хариуцлагатай засаглалыг хэрэгжүүлэх хүрээнд олон нийт, хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид, харилцагчид болон зохицуулагч байгууллагуудад Банкны талаарх мэдээллийг үнэн зөв,

бүрэн бүтэн, тэнцвэртэй бөгөөд цаг тухайд нь хүргэхийг чухалчилдаг. Энэхүү зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор Банк нь “ХААН Банк ХК-ийн Мэдээллийн ил тод байдал, мэдээллийг толилуулах бодлого”-ыг баталж, үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлдэг. Банк нь мэдээлэл толилуулахдаа үнэн зөв, хүртээмжтэй, цаг тухайд нь, бүрэн бүтэн, бодитой, эерэг болон сөрөг талуудыг хамарсан тэнцвэртэй байдлыг хангаж, холбогдох хууль тогтоомж, Банкны Дүрэм, тус бодлого болон бусад дотоод баримт бичгүүдийн дагуу ил тод байдал болон бизнесийн ашиг сонирхлын хооронд зохистой тэнцвэрийг хадгалахыг эрмэлзэж ажилладаг. Банк нь өөрийн үйл ажиллагаа, засаглалын тогтолцоо, санхүүгийн болон санхүүгийн бус гүйцэтгэл, хэтийн төлөв, баримталж буй стратеги, хэрэгжилттэй холбоотой мэдээллийг Банкны цахим хуудас, Биржийн цахим хуудас, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон мэдээллийг саадгүй, хүртээмжтэй хүргэх боломжтой бусад хэлбэрээр дамжуулан хүргүүлж оролцогч талуудыг шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангах, зах зээлийн итгэлийг бэхжүүлэх, тогтвортой хөгжлийг дэмжих суурийг бүрдүүлж байна.

• Шүгэл үлээх бодлого

ХААН Банк нь компанийн зохистой засаглалыг хэрэгжүүлж, байгууллагын хэмжээнд бизнесийн ёс зүй, ил тод байдал, хариуцлага болон шударга байдлын зарчмуудыг баримтлан үйл ажиллагаагаа Монгол Улсын хууль тогтоомж, зохицуулагч байгууллагуудаас баталсан дүрэм, журмын дагуу явуулдаг. Банк нь аливаа хууль бус үйлдэл, ёс зүйн зөрчил ба шударга бус байдлын талаар эмээх зүйлгүйгээр мэдээлэх боломжийг ажилтнууд, харилцагчид болон бусад хамтран ажиллагч хувь хүн, байгууллагуудад олгох зорилгоор “ХААН Банк ХК-ийн Шүгэл үлээх бодлого”-ыг хэрэгжүүлдэг. Уг бодлогын хүрээнд 2024 онд шүгэл үлээх явцыг цахимжуулж, Банкны цахим хуудсанд "Шүгэл үлээх" тусгай цэсийг нэвтрүүлсэн. Энэ шийдэл нь оролцогч талуудад зөрчил, хууль бус үйлдлийн мэдээллийг аюулгүй, нууцлалтай, шуурхай дамжуулах боломжийг бүрдүүлж, засаглалын ил тод байдал, хариуцлагыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой алхам юм.

• Ёс зүйн дүрэм

Банкны нийт ажилтнуудын өдөр тутмын үйл ажиллагаандаа дагаж мөрдөх ёс зүйн нийтлэг хэм хэмжээг тогтоосон “Ёс зүйн дүрэм”-ийг Банкны хэмжээнд үндсэн зарчим болгон баримталдаг. Ёс зүйн дүрэм нь ХААН Банкны үнэт зүйлсийн тунхаг бичигт тусгасан эрхэмлэх үнэт зүйлсийг бэхжүүлэх, харилцагч, ажил хэргийн түнш, хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн гишүүд, банкны ажилтнуудын өмнө хүлээсэн, албан үүрэг, хариуцлагаа биелүүлэх, тэдний ашиг сонирхлыг хамгаалах, тэдгээрийг хоорондын харилцааны үндсийг тодорхойлох зорилтыг хэрэгжүүлнэ. ХААН Банкны Ёс зүйн дүрмийн 6.3-т заасны дагуу Банк нь хууль бус хөдөлмөр эрхлэлтийн эсрэг сайн туршлага хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын нэгдэн орсон НҮБ, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас баталсан Конвенц, олон улсын бусад хэм хэмжээг мөрдлөг болгон ажилладаг.

“ХААН Банкны ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Ёс зүйтэй банкир” төслийг жил бүр тогтмол хэрэгжүүлж байна. Төсөл нь ADKAR аргачлалд тулгуурлан эхний жилүүдэд ёс зүйн мэдлэг, урьдчилан сэргийлэх чадавхыг нэмэгдүүлэх, холбогдох бодлого журмыг шинэчлэхэд төвлөрсөн бол 2025 онд тогтсон соёлыг гүнзгийрүүлэхэд чиглэн, ёс зүйн элчийн тогтолцоог нэвтрүүлж, нийт 41 элчээр дамжуулан банкны бүх газар, нэгж, ажилтнуудад хүрч ажилласан байна. Мөн удирдах ажилтнуудад зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг тогтмол хүргэх, танхим болон цахим сургалтуудыг зохион байгуулах, видео контент, дотоод мэдээллийн сувгаар дамжуулан ёс зүй, эрсдэлийн талаарх мэдлэгийг системтэйгээр түгээн ажиллаж байна. Үүний үр дүнд ажилтнуудын өдөр тутмын үйл ажиллагаанд ёс зүйг эрхэмлэх, мэргэжлийн зан төлөвийг хэвшүүлэх соёл бэхжиж, байгууллагын эерэг ажлын орчин, бүтээмж нэмэгдэхэд чухал хувь нэмэр оруулсан.

• Харилцагчийн туршлага

ХААН Банк нь Тогтвортой дунд хугацааны бизнес стратегийн хүрээнд харилцагчийн туршлагыг тэргүүлэх зорилт болгон тодорхойлж, харилцагчийн сэтгэл ханамжийг тогтвортой өндөр түвшинд хадгалах чиглэлээр ажиллаж байна. Үүний хүрээнд харилцагчийн санал хүсэлтийг системтэй хүлээн авч, дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан тасралтгүй сайжруулалтын тогтолцоог бүрдүүлсэн.

Үндсэн чиглэлүүд:

- Найдвартай, ил тод, тогтвортой үйл ажиллагаа явуулах

- Түргэн шуурхай, үр ашигтай, чанартай үйлчилгээ үзүүлэх
- Санал, гомдлыг нээлттэй сонсох, шийдвэр гаргалтад бодитоор тусгах
- Хэрэгцээ, сегментэд нь тохирсон, уян хатан нөхцөлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ санал болгох
- Байршил, цаг хугацааны хязгаарлалтгүйгээр ашиглах боломжтой дижитал шийдэл, сувгуудтай байх
- Тулгамдсан асуудлыг шуурхай, мэргэжлийн түвшинд шийдвэрлэх

Эдгээр зарчимд тулгуурлан банк нь харилцагчийн туршлага төвтэй соёлыг төлөвшүүлж, үйлчилгээний чанар, хүртээмжийг олон улсын жишигт нийцүүлэн тасралтгүй сайжруулж байна.

ХААН Банк нь Харилцагчийн эрх ашгийг хамгаалах бодлогыг үйл ажиллагааныхаа үндсэн зарчим хэмээн тодорхойлж, энэ хүрээнд системтэйгээр үйл ажиллагаа явуулан, дараах үндсэн зарчмуудыг баримтлан ажиллаж байна.

- Шударга харилцах - Харилцагчдад шударга, хүндэтгэлтэй үйлчилж, харилцагчийн банкинд итгэх итгэлийг бататгах
- Хэрэгцээнд нийцэх - Харилцагчийн хэрэгцээнд тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээг тодорхойлсон сегментээр үзүүлэх
- Ил тод, хүртээмжтэй байх - Бүтээгдэхүүн үйлчилгээний мэдээлэл сурталчилгаа, тайлбар зөвлөгөөг үнэн зөв, шуурхай, хүртээмжтэй байдлаар хүргэх, харилцагчийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх
- Нууцлалыг хангах - Харилцагчийн мэдээллийг хамгаалж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах
- Гомдол, саналыг үнэн зөв шийдвэрлэх - Харилцагчийн өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, зөрчлийн хууль, дүрэм журмын дагуу шийдвэрлэх

6. Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл

Банк нь зах зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд хүү, гадаад валютын ханш болон үнийн өөрчлөлт зэрэг зах зээлийн хувьсагчдын өөрчлөлтөөс шалтгаалан банкны эзэмшиж буй санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ, ирээдүйн мөнгөн урсгалын хэлбэлзлээс хүлээж болзошгүй алдагдлыг хүлээн зөвшөөрөх эрсдэлийн түвшинд удирдаж ажиллалаа.

Банк зах зээлийн эрсдэлд өртөх боломжтой бөгөөд энэхүү эрсдэлд валютын ханш, хүүгийн түвшин, өмчийн хэрэглүүр болон санхүүгийн хэрэглүүрүүд (үүнд үүсмэл санхүүгийн хэрэглүүр орно)-ийн нээлттэй позицоос үүсэх эрсдэлүүд ордог ба эдгээр нь зах зээлийн ерөнхий болон тусгай өөрчлөлт, хөдөлгөөнд өртдөг.

Гадаад валютын ханшийн хэлбэлзлээс үүсэж болзошгүй алдагдлыг тэдгээрийн эрсдэл даах чадвартай уялдуулах зорилгоор Монголбанкнаас тогтоосон тухайн нэг болон нийт гадаад валютын нээлттэй позицын хязгаарлалтуудыг хангахын зэрэгцээ “Хамгийн их эрсдэлийн арга”-аар эрсдэлээ өдөр тутам хэмжин, удирдаж ажилладаг. Банкны гадаад валютын эрсдэлийн үнэлгээний “VaR” програм хангамж нь гадаад валютын нээлттэй позицоос хүлээх ханшийн эрсдэлийг 99 хувийн итгэх магадлалын түвшинд түүхэн эх үүсвэр, вариаци-ковариаци болон симуляцын аргачлалуудыг ашиглан тооцож мөн удирдлагын мэдээллийн систем болон эрсдэлийн үнэлгээний найдвартай, үнэн зөв бөгөөд бүрэн бүтэн байдлыг хангахад чиглэсэн стандарт тоон ба чанарын шаардлагуудад нийцүүлэн тогтмол хөгжүүлэлтүүдийг хийдэг.

Үүний зэрэгцээ зах зээл дэх хүүний түвшний өөрчлөлт нь богино хугацаанд банкны цэвэр хүүгийн орлогод шууд нөлөөлдөг бол урт хугацаанд өөрийн хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнд нөлөөлдөг. Банк нь банкны хяналт, шалгалтын Базелийн хорооноос боловсруулсан аргачлал, түүнд тодорхойлсон хүүний түвшний стандарт болон шокийн сценари хувилбаруудыг ашиглан хүүний түвшний эрсдэлээ хэмжиж, лимит тогтоох замаар сөрөг нөлөөллийг хязгаарладаг. Үүнд:

- Арилжааны бүртгэлийн хүүний түвшний эрсдэлийг хөрвөх чадвараар тохируулсан хамгийн их эрсдэлийн аргачлалд суурилан;
- Банкны бүртгэлийн хүүний түвшний эрсдэлийг орлого болон эдийн засгийн өртгийн хандлагын аргачлалуудаар хэмжиж, удирддаг.

Банк үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн гэрээний эрсдэлд өртөх дүнг Банкны зах зээлийн эрсдэлийн удирдлагын бүхий л хүрээнд хянадаг. Банк хейджийн зүйлийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тооцоолохдоо таамаглалын дериватив аргыг ашигладаг. Таамаглалын дериватив арга нь хейджийн эрсдэлд өртөхөд хамгийн тохиромжтой хейджийн хэрэглүүр болох нэрлэсэн деривативыг бий болгох явдал юм. Таамаглалын деривативын бодит үнэ цэнийг бодит хейджийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлттэй харьцуулах замаар хейджийн ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн цэвэр үнэ цэнийн төлөөлөл болгон ашигладаг.

Түүнчлэн банк нь өөрийн үйл ажиллагааны онцлог, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан үүсэж болох эрсдэлийг урьдчилан тооцож түүнийг тэсвэрлэх хангалттай хэмжээний өөрийн хөрөнгө ба төлбөрийн чадварыг хадгалах эсвэл шаардлагатай нэмэлт нөөцийг хэрхэн бүрдүүлэх болон эрсдэлийн түвшинг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн стресс тестийн шинжилгээг улирал тутам хийж гүйцэтгэдэг. Банк нь олон улсад өргөн ашиглагддаг шилдэг туршлага, стандартыг жишиг болгон зах зээлийн эрсдэлийг хэмжих загвар ба аргачлалыг хөгжүүлэх, үр ашигтай дотоод эрсдэлийн лимит тогтоох үйл явцыг бий болгох болон эрсдэл бууруулах арга хэрэгслүүдийг ашиглах замаар эрсдэлийн удирдлагын тогтолцоог тасралтгүй сайжруулж ажиллахыг зорьдог.

7. Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, ХААН Банкны Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1-д тус тус заасны дагуу ХААН Банкны эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус хурал хуралдуулах замаар банкныг удирдах ба хувьцаа эзэмшигчид хуралд өөрсдийн эзэмшиж буй хувьцааны тоогоор саналын эрхтэй оролцоно. Банкны хувьцааг эзэмшиж буй хүн бүр Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх

Банкны Хувьцаа эзэмшигчдийн хурал нь Монгол Улсын Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйл, Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйл болон Банкны Дүрмийн 7.2-т тус тус заасны дагуу дараах асуудлуудыг хэлэлцэх, шийдвэрлэх бүрэн эрхтэй байна.

2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

ХААН Банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу жилд нэгээс доошгүй удаа зарлан хуралдуулдаг бөгөөд 2025 оны ээлжит хурлыг 04 дүгээр сарын 24-ний өдөр танхим болон цахим хосолсон хэлбэрээр амжилттай зохион байгуулсан. Хуралд оролцсон саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн санал хураалтаар дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж баталсан болно. Үүнд:

1. “ХААН Банк” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлав.
2. ТУЗ-ийн 2025 оны зардлын төсвийг батлав.
3. “ХААН Банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах шинэчилсэн төлөвлөгөө”-ний төслийг батлав.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

Банк нь нийт 3,000,000,000 ширхэг энгийн зарласан хувьцаатай бөгөөд үүнээс нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,912,198,000 ширхэг энгийн хувьцаа гаргасныг 34,601 хувьцаа эзэмшигч эзэмшиж байна.

Банкны гаргасан хувьцааг дараах хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна. Үүнд:

Хувьцаа эзэмшигч	Хувь	Хувьцааны тоо ширхэг
Эйч Эс Холдингс ХК	40.99%	783,882,300
Эйч Эс Интернэйшнл (Ази) Лимитед	8.78%	167,856,050

Таван Богд Холдингс ХХК	22.78%	435,653,100
Д.Хулан (хувь хүн)	13.22%	252,738,000
Олон нийт	14.23%	272,068,550
Нийт	100%	1,912,198,000

Хувьцаа эзэмшигчдийн талаар:

- **Эйч Эс Холдингс ХК**

Эйч Эс Холдингс ХК нь 1958 онд анх үүсэн байгуулагдсан бөгөөд хувьцаагаа олон нийтэд арилжаалдаг (Токиогийн хөрөнгийн биржийн бүртгэлийн дугаар: 8699) нээлттэй хувьцаат компани юм. Тус компани нь гол төлөв үнэт цаасны арилжаа, зуучлал, хоёрдогч бүтээгдэхүүнээс гадна компаниудад үнэт цаас гаргаж, тэдгээрийг бусдад санал болгох, арилжих үйлчилгээ, мөн банк, үл хөдлөх хөрөнгө, шинээр үйл ажиллагаагаа эхэлж буй компаниудад хөрөнгө оруулах зэрэг санхүүгийн олон төрлийн үйлчилгээ үзүүлдэг.

- **Эйч Эс Интернэйшнл (Ази) ХХК**

Эйч Эс Интернэйшнл (Ази) ХХК нь Эйч Эс Холдингс ХК-ийн Хонконг дахь охин компани юм. Тус компани нь Хятад болон Ази тивийн эдийн засгийн өсөлт дээр тулгуурлан Ази дахь стратегийг хэрэгжүүлж, бүс нутгийн улс орнуудын зах зээлийн судалгаа хийхээс гадна Хонгконгийн зах зээлд бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг.

- **Таван Богд Холдингс ХХК**

Таван Богд Холдингс ХХК нь Таван Богд Группийн толгой компани ба цруппийн бодлого стратеги, менежментийг нэгдсэн байдлаар тодорхойлох, шинэ бизнесийг нээн хөгжүүлэх, хөрөнгө оруулалт болон салбар компаниуддаа менежментийн дэмжлэг үзүүлэх зорилготойгоор байгуулагдсан. Таван Богд групп нь худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэл, аялал жуулчлал болон зочид буудал, уул уурхайн тоног төхөөрөмжийн бэлтгэн нийлүүлэлт, банк санхүү зэрэг салбарт үйл ажиллагаа явуулдаг. Мөн “Toyota”, “Geely”, “Хегох” зэрэг брэндийн албан ёсны дистрибьютерээр, “KFC”, “Pizza Hut”, “Subway” брэндийн сүлжээ ресторануудын Монгол Улс дахь албан ёсны франчайз эрхийг эзэмшдэг.

- **Д.Хулан**

Монгол Улсын иргэн Д.Хулан нь Таван Богд Группийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч бөгөөд одоо Таван Богд Холдингс ХХК-ийн ТУЗ-ийн даргаар ажиллаж байна. Д.Хулан нь банкны ТУЗ-ийн ердийн гишүүн, ТУЗ-ийн дэд дарга бөгөөд 2010 оноос бие даасан хувьцаа эзэмшигч болсон.

- **Олон нийт**

ХААН Банк нь Банкны тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд 2023 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр анхдагч зах зээлийн арилжааг амжилттай зохион байгуулж, нийт хувьцааныхаа 10 хувийг олон нийтэд санал болгосон нь Монголын хөрөнгийн зах зээлийн түүхэнд хамгийн өндөр дүнтэй, хамгийн олон захиалга авсан, хамгийн олон хөрөнгө оруулагч хамрагдсан арилжаа болсон. Мөн банкны ажилтанд хувьцаа худалдах хөтөлбөрийн хүрээнд 4,136 ажилтны эзэмшиж байсан хувьцааны тусгаарлалтын хугацаа 2023 онд дууссантай холбогдуулан хувьцааг үнэт цаасны данс руу шилжүүлснээр олон нийтэд хамаарах хувьцааны хэмжээ 272,068,550 ширхэг буюу нийт хувьцааны 14.23 хувьд хүрсэн болно.

8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл
----	--

ХААН Банк нь 2023 оны 4 дүгээр сарын 13-ны өдрөөс 4 дүгээр сарын 19-ний өдрийн хооронд олон нийтэд нэгж бүр нь 959 төгрөгийн үнэтэй 191,219,800 ширхэг энгийн хувьцааг санал болгон арилжиж, нийт 183.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлсэн.

Татан төвлөрүүлсэн хөрөнгийг стратегийн тэргүүлэх чиглэлүүдэд хуваарилан ашиглахаар төлөвлөсөн бөгөөд уг төлөвлөгөөний дагуу 16 хувийг банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний цахим шилжилтийг хурдасгах мэдээллийн технологийн хөрөнгө оруулалтад, 19 хувийг цахим бүтээгдэхүүний хөгжүүлэлт, шинэчлэлтэд, 34 хувийг ногоон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд, 31 хувийг урт хугацаат хөрөнгө оруулалтын болон орон сууцны зээл олголтод тус тус зарцуулсан.

Ингэснээр татан төвлөрүүлсэн нийт хөрөнгийг үнэт цаасны танилцуулгад тусгасан зорилт, төлөвлөгөөний дагуу бүрэн ашиглаж, хэрэгжилтийг хангаж ажилласан болно.

9. Ногдол ашгийн мэдээлэл

“ХААН Банк ХК-ийн Ногдол ашгийн бодлого”-ыг Банкны ТУЗ-ийн 2023 оны шийдвэрээр баталсан. Уг бодлого нь Банкны ТУЗ-өөс баримтлах ногдол ашгийн бодлого, ногдол ашиг хуваарилах нөхцөл, журмыг Банкны тухай хууль, Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын дүрэм, журамд нийцүүлэн тодорхойлох зорилготой. Тус бодлогод заасны дагуу Банк нь жил бүр татварын дараах цэвэр ашгийн 40 хувиас дээш хувиар ногдол ашиг хуваарилахыг эрмэлзэж ажилладаг ба зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлдэг компанийн хувьд Монголбанкнаас зөвшөөрөл авсны үндсэн дээр хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хуваарилдаг.

ХААН Банкны ТУЗ-ийн 2025 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 04 тоот тогтоолоор 2024 оны татварын дараах цэвэр ашиг болох 638.5 тэрбум төгрөгөөс Банкны өөрийн эрсдэл даах чадвар, өөрийн хөрөнгийн зохистой харьцааг зохих түвшинд хадгалах нөхцөлийг хангасны үндсэн дээр нэгж хувьцаанд 195.35 төгрөг буюу 1,912,198,000 ширхэг энгийн хувьцаанд нийт 373.5 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн. Уг шийдвэрийн дагуу ногдол ашиг авах эрхтэй 32,708 хувьцаа эзэмшигчдэд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-иар дамжуулан хуваарилж дууссан болно.

10. Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл

ХААН Банк 2007 онд нийгмийн өмнө хүлээсэн үүргээ ухамсарлаж, ард иргэдийн сайн сайхан амьдралын төлөө бодитой хувь нэмэр оруулахаар нийгмийн хариуцлагын ажлуудыг ХААН Банк сангаараа дамжуулан бие даан хэрэгжүүлж эхэлсэн юм. ХААН Банк сан нь тогтвортой байдлын бодлого, стратегийн үндсэн чиглэлийн нэг болох Нийгмийн хэсэгт багтаж буй нийгмийн хариуцлагын ажлуудыг хэрэгжүүлдэг нэгж юм. ХААН Банк сан өнгөрсөн 19 жилийн хугацаанд нийт 536 төсөл хэрэгжүүлж, 27,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийж, нийт 528,000 хүнд хүрч ажилласан. Тайлант оны хувьд нийт 12 төсөл хэрэгжүүлснээр 9 төлөвлөгөөт, 3 шинэ төслүүдийг хэрэгжүүлсэн.

Үүнд:

1. ХААН Банкны нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд 100 оюутанд тэтгэлэг олгосон
2. ХААН Банкны ой хөтөлбөрийн хүрээнд 500 га газарт 1,1 сая гаруй мод тарьсан
3. Хавдрын эсрэг үндэсний аян 2 аймагт хэрэгжиж, нийт 2,734 хүнд хүрч ажилласан
4. Ховд аймгийн 45 багшид сургалтын ухаалаг багц гардуулсан
5. Lumos VR төслийн хүрээнд Баянхошуу бизнес инкубатор төвд AR/VR төхөөрөмжтэй танхим тохижуулсан
6. Цацралт кап-2025 тэмцээнийг дэмжин ажилласан
7. Орон даяар 3х3 сагсан бөмбөгийн “KHAN CUP – 2025” тэмцээнийг амжилттай зохион байгуулсан. Тэмцээнд нийт 2000 хүүхэд аймаг, бүс, улсын аваргын төлөө өрсөлдсөн
8. Цусны даралт ихсэлтийн эсрэг аяныг 3 байршилд хэрэгжүүлэн нийт 12,760 хүнд хүрч ажилласан
9. “RISE” оюутны хөгжлийн хөтөлбөрийг Дорнод аймагт зохион байгуулж, нийт 500 оюутныг хамруулсан
10. Пара бочи спортын хөгжилд хувь нэмрээ оруулж зорилтот бүлгийн 100 хүртэлх тамирчдад 100 сая төрөгийн санхүүжилт олгосон
11. Багийн бага сургуулийг 4 байршилд бүтээн байгуулж, 300 хүүхдийн сурах нөхцлийг бүрдүүлсэн

12. Би монгол хүн хөтөлбөрт нийт 600 хүүхдийг хамруулсан

ХААН Банк “Тогтвортой хөгжилд манлайлагч” үнэт зүйлийн хүрээнд 2025 оны 9 дүгээр сард Байгаль орчин, Нийгэм, Засаглал, Хариуцлагатай банк гэсэн дөрвөн тулгуур баганы хүрээнд тодорхойлсон “Тогтвортой байдлын стратеги 2030” болон 2025 оны 12 дугаар сард “Тогтвортой байдлын бодлого”-ыг тус тус батлаад байна. ХААН Банкны “Тогтвортой байдлын тайлан 2025” нь СЗХ болон бусад санаачлагч байгууллагуудын дэмжлэгтэй гаргасан БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын удирдамж, Монголын санхүүгийн байгууллагуудад зориулан Монголбанкнаас манлайлан гаргасан Уур амьсгалын нөлөөллийн тайлагналын удирдамжийн дагуу боловсруулагдсан. Мөн СТОУС сангийн дэргэдэх Олон улсын тогтвортой байдлын стандартын зөвлөл (ОУТБСЗ)-өөс баталсан Тогтвортой байдлын тодруулгын стандарт (СТОУС ТБ1) болон Уур амьсгалтай холбоотой ил тод тайлагналын стандарт (СТОУС ТБ2)-ын шаардлагуудтай энэхүү тайланг нийцүүлэхийг зорьсон. Үүнээс гадна, санхүүгийн салбар, тэр дундаа арилжааны банкны үйл ажиллагаанд материаллаг ач холбогдол бүхий тогтвортой байдлын асуудлуудыг тусгах зорилгоор Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөл (ТБНББСЗ)-ийн “Арилжааны банкууд” салбарын стандартад багтсан материал асуудлуудын хүрээнд эрсдэл, боломжийг тайлагналаа.

Эдгээр дотоодын болон олон улсын тайлагналын стандартыг хэрэгжүүлэхдээ ХААН Банк “давхар материаллаг байдлын үнэлгээ”-ний аргачлалыг сонгон гүйцэтгэж 1) ХААН Банкны үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг ба сөрөг нөлөөллийг тодорхойлон тайлагнасан; 2) Хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засагын хүрээнд Банкны БОНЗ-ын асуудлын хүрээнд нөлөөлж болзошгүй эрсдэл ба боломжуудыг тодорхойлон Банк үүнд ямар арга хэмжээ авч буй талаар “Тогтвортой байдлын тайлан 2025”-ийн “Материаллаг асуудлуудын эрсдэл ба боломжууд” хэсгээс дэлгэрэнгүй танилцана уу.

“Давхар материаллаг байдлын үнэлгээ”- ний үр дүн болох 14 давхар материал асуудлуудын хүрээнд Тогтвортой байдлын стратегийн 2030 онд хүрэх 20 зорилтуудыг тодорхойлон ил тодоор тайлагнасан бөгөөд хэмжих гол үзүүлэлтүүдийг 2025 оны байдлаар тайлагнан олон нийтэд хүргэхийг зорьлоо.

ХААН Банк нь уур амьсгалын эрсдэлүүдийг анхааран үзэж, байгууллагын нэгдсэн эрсдэлийн удирдлагын хүрээнд үр дүнтэй удирдаж, хянах үе шаттай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдэлийн хүрээнд банкны стратеги, бизнес болон үйл ажиллагаанд тохиолдож болзошгүй гол эрсдэлийн төрлүүдийг авч үздэг. Тодруулбал, 2025 онд Банкны бизнес зорилго зорилт болон зохицуулагч, зээлдүүлэгч байгууллагын шаардлагад сөргөөр нөлөөлөх уур амьсгалын эрсдэлийг бага түвшинд байлгах зорилгоор 2025 оны Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдэл (ХЗЭМ)-ийн хүрээнд уур амьсгалын эрсдэлийг хэмжиж, удирдах үзүүлэлтүүдийг тодорхойлон батлуулсан. Эдгээр үзүүлэлтүүдийн гүйцэтгэлийг улирал бүр холбогдох хороо болон ТУЗ-д тогтмол тайлагнан ажиллаж байна. Мөн уг батлагдсан үзүүлэлтүүдийн хүрээнд Уур амьсгалын биет болон шилжилтийн эрсдэлийн хувьд зээлийн багцад нөлөөлөх нөлөөллийг хянах зорилгоор Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК)-ийн зөвлөх үйлчилгээний зөвлөмжүүдэд үндэслэн холбогдох дэд үзүүлэлтүүдийг туршилтын байдлаар тодорхойлон, батлуулсан бөгөөд Гүйцэтгэх удирдлагын түвшинд тайлагнаж байна. Түүнчлэн Банк нь үйл ажиллагааны тэсвэртэй байдлыг хангах хүрээнд биет болон мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах холбогдох үзүүлэлтүүдийг ХЗЭМ-д тодорхойлон баталсан.

Мөн Банкны эрсдэлийн самбар (Risk Dashboard) нь гол эрсдэлүүдийг удирдаж, хянах арга хэрэгсэл бөгөөд банкны зорилтод нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх болон тогтмол хянах замаар гол эрсдэлүүдийг үр дүнтэй удирдах зорилготой юм. Үүний хүрээнд “Уур амьсгалын нөлөөллийн эрсдэл”, “Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлүүд”-ийг тодорхойлж, тусгасан ба тус эрсдэлүүдийн түвшинг сар тутам үнэлдэг.

Түүнчлэн ОУСК-ийн техникийн туслалцааны хүрээнд уур амьсгалын эрсдэлийн удирдлагын механизмийг бүрдүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Энэ хүрээнд дараах дөрвөн гол үйл ажиллагааг 2025 онд хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Уур амьсгалын стратеги: ОУСК-аас банкны уур амьсгалын эрсдэлийн стратегийн одоогийн нөхцөл байдалд оношилгоо хийж, олон улсын стандарт, шилдэг туршлагад нийцүүлэх зөвлөмжүүдийг боловсруулан банканд ирүүлсэн.

- Зээлийн багцын биет эрсдэлийн үнэлгээ: ОУСК-аас Банкны зээлийн багцад уур амьсгалын биет эрсдэлийн хүчин зүйлсийн нөлөөллийг тодорхойлох зорилгоор газарзүйн болон салбарын эмзэг байдлын үнэлгээг хийж, үр дүнг нэгтгэсэн “Биет эрсдэлийн үнэлгээний тайлан”-г боловсруулан банканд хүргүүлсэн.
- Шилжилтийн эрсдэл, санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгарлын тооцоолол: Банкны санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгарлыг тооцоолох, мөн Парисын хэлэлцээрийн зорилтуудтай хэр зэрэг нийцэж буй болон нийцэхгүй салбаруудыг тодорхойлох ажлууд хийгдэж дууссан. Үүний хүрээнд ОУСК-иас санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгарлын тооцооллын загваруудыг ирүүлсэн ба Банк боломжит бүх холбогдох тооцооллыг хийсэн. Мөн ОУСК нь тус тооцооллын үр дүнд тулгуурлан Банканд 2050 он хүртэлх Цэвэр тэг ялгаруулалт (Net Zero) зорилтод хүрэхэд чиглэсэн ерөнхий түвшний шилжилтийн стратегийг тодорхойлоход дэмжлэг үзүүлэн ажилласан бөгөөд энэхүү ажлын хүрээнд Банк нь бизнесийн зээл, автомашины зээл, орон сууцны зээл, хувьцаа, бонд зэрэг санхүүжилтийн багцуудын хүлэмжийн хийн ялгарлыг тооцсон.
- Уур амьсгалын эрсдэлийн удирдлагын бодлого, журмуудын сайжруулалт: Банк нь ОУСК-аас уур амьсгалын эрсдэлийн удирдлагын үйл явцыг Байгууллагын нэгдсэн эрсдэлийн удирдлагын бодлого, Зээлийн үйл ажиллагааны журам, Санхүүгийн бус эрсдэлийн удирдлагын бодлого зэрэг эрсдэлийн удирдлагын үндсэн баримт бичгүүдэд тусган сайжруулах чиглэлийн санал, зөвлөмжүүдийг хүлээн авсан.

Мөн чиглэл хариуцсан эрсдэлийн дэд хороод болох Үйл ажиллагааны эрсдэлийн дэд хороо, Аюулгүй байдлын эрсдэлийн дэд хороод нь хариуцсан эрсдэлүүдийг нэгдсэн байдлаар хянаж удирдаж, холбогдох шийдвэрүүдийг гаргаж ажилладаг.

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Р.Мөнхтуяа

Албан тушаал: Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:



Он, сар, өдөр: 2026 он 04 дүгээр сарын 30-ны өдөр